

ГАРЧИГ

2–3 ББСБ–уудын санхүүгийн болон мэргэжлийн чадавх сайжирч, үйл ажиллагааны далайц нэмэгдэж байна

4–5 Зохицуулалтын мэдээ

5–7 ББСБ–ын хяналт, зохицуулалтын түүхэн замнал

7–9 Тайлбар ба зөвлөмж – ББСБ–ын үйл ажиллагаатай холбоотой асуулт, хариулт

9–11 Финтек ба Рэгтек

12–14 Судлаачын индэр – Иргэдийн санхүүгийн зах зээлийн оролцоо

14–16 СЗХ болон Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны хамтын ажиллагаа

17–19 Өргөн дуран–Монголын банкны бус санхүүгийн зээлийг хөгжүүлэх шаардлага

19–20 Хэрэглэгч

21–24 Зах зээлийн мэдээ

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- 8 Монгол Улс, Улаанбаатар хот 15160 Чингэлтэй дүүрэг, Бага тойруу–3 Засгийн газрын IV байр.
- 976 51 261611
- press@frc.mn
- www.frc.gov.mn
- Санхүүгийн зохицуулах хороо
- @FRC_of_Mongolia

Хэвлэл мэдээллийн алба

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН СУДАЛГАА: ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОО

Хөрөнгийн зах зээл: Хөрөнгийн зах зээл бол санхүүгийн зах зээлийн нэг чухал салбар юм. Иймд энэхүү судалгааны хүрээнд хөрөнгийн зах зээлийн оролцооны талаар иргэдээс хэд хэдэн асуултаар мэдээлэл авсан.

Иргэдийн 17.2 хувь нь хөрөнгийн биржийн арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож байсан гэж хариулсан бол 82.6 хувь нь үгүй, 0.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан. Мөн 2018 оны 3 дугаар улирлын судалгаагаар энэхүү асуултад 30.1 хувь нь мэдэхгүй гэж хариулж байсан бол 2019 оны 2 дугаар улиралд энэ хариулт 0.2 хувь болж огцом буурчээ.

Боловсрол өндөр, орон сууцанд амьдардаг, өндөр орлоготой, эрэгтэй, хотод амьдардаг иргэдийн 20 гаруй хувь нь хөрөнгийн биржийн арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож байсан бол боловсрол бага, гэрт амьдардаг, орлого багатай, эмэгтэй, хөдөө амьдардаг иргэдийн 10 гаруй хувь сонирхож байжээ.

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХҮРТЭЭМЖ: ФИНТЕКИЙН ӨНӨӨГИЙН ОРЧИН, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ

финтекийн бүтээгдэхүүн үйлчилгээнүүдээр дамжин санхүүгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлснээр тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх боломж өсөж байна. Ядуучуудад туслах зөвлөлдөх бүлэг /CGAP–ийн гаргасан судалгаанаас үзэхэд санхүүгийн хүртээмж нэмэгдсэнээр дараах тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх боломжтой юм. Үүнд:

- Ядуурлыг бууруулах
- Өлсгөлөнг бууруулж хүнсний аюулгүй байдлыг хангах
- Хүн амын эрүүл мэнд болон сайн сайхан байдлыг дээшлүүлэх
- Боловсролын чанарыг сайжруулах
- Жендерийн тэгш бус байдлыг бууруулах

Дээрх тогтвортой хөгжлийн зорилтууд болон хүн амын сайн сайхан байдалд оруулж буй хувь нэмрээс нь үзэхэд санхүүгийн инноваци нь нийгэмд өөрчлөлт авчирхуйц биет болон биет бус хөрөнгийг бүтээж, хөгжиж буй болон өндөр хөгжилтэй орнуудын тэгш бус мэдээлэл, өрсөлдөөний ялгааг бууруулан, нийгмийн хүртээмжийг сайжруулж тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулж байна. Товчоор хэлбэл, санхүүгийн салбар болон тогтвортой хөгжлийн гүүр нь санхүүгийн инноваци болж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны

АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Цогц мөн чанар: Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, ур чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.



ББСБ–УУДЫН САНХҮҮГИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН ЧАДАВХ САЙЖИРЧ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДАЛАЙЦ НЭМЭГДЭЖ БАЙНА



Б.ИТГЭЛСҮРЭН

БАНК БУС
САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

ББСБ–ын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр бодлогын ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байна вэ? Үүнээс яриагаа эхлэх үү?

Эн тэргүүнд бодлогын түвшинд эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хийгдэж байгаа ажлынхаа талаар ярих нь зүйтэй байх.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль 2002 онд УИХ–аас батлагдаж байсан. Өнөөдөр ББСБ–ын эрхэлж байгаа үйл ажиллагааны хамрах хүрээ, бүтээгдэхүүн үйлчилгээ зэргээс шалтгаалаад тус хуулийн үзэл баримтлалыг эргэн харах, шинэчлэн найруулах зайлшгүй шаардлага үүссэн. Иймээс Хороо эхний ээлжинд өөрсдийн нөөц боломжиндоо тулгуурлан хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулаад байна. Энэ чиглэлээр Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банканд хүсэлт тавьснаар техникийн туслалцааны хүрээнд гадаад, дотоодын зөвлөх багийг сонгон шалгаруулж 2018 оноос хамтран ажиллаж эхлээд байна. Энэхүү зөвлөх баг нь зөвхөн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр хамтран ажиллахаас гадна салбарын зохицуулалтын журам, заавруудыг сайжруулах, боловсронгуй болгоход туслалцаа үзүүлэн ажиллахаар харилцан тохиролцсон.

Хорооны зүгээс цаг алдалгүйгээр одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд ББСБ–ын үйл ажиллагааны хяналт, зохицуулалтын журмуудыг шинэчлэн

боловсруулан ажиллаж байна. Тухайлбал, хяналт шалгалтын болон нягтлан бодох бүртгэлийн багц журам, зааврууд гэх мэт.

Тодруулж хэлбэл, ББСБ–уудын тоотой харьцуулахад тэдгээрийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан мэдээнд тогтмол хяналт тавих Хорооны хяналт шалгагчдын хүрэлцээ дутмаг байна. Иймд хяналт, шалгалтын журмыг зайны болон эрсдэлд суурилсан хяналт талаас нь илүү үр өгөөжтэй болгохоор ажиллаж байгаа юм.

Өнгөрсөн хугацаанд ББСБ–ын салбарт ямар өөрчлөлт, ахиц дэвшил гарсан талаар та дурдахгүй юу?

Хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд Хороо улсын эдийн засаг, мөнгөний ханшийн өөрчлөлт, ББСБ–уудын төлбөрийн чадвар, үйл ажиллагааны онцлогийг харгалзан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоодог. ББСБ–ын өсөлт, дэвшлийг ярихын тулд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Хорооноос хэрхэн тогтоож байсныг зайлшгүй ярих ёстой.

Хороо ББСБ–ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2008 онд үйл ажиллагааны онцлогоос нь хамааруулан 0.1, 0.4, 1.0 тэрбум төгрөгөөр тогтоож байснаас хойш өөрчлөлт оруулж байгаагүй. Өөрөөр хэлбэл, тухайн үед валютын арилжаа эрхлэх ББСБ–уудын хувьд 0.1 тэрбум төгрөг, зээл, факторинг, төлбөрийн баталгаа гаргах болон хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх бол 0.4 тэрбум төгрөг, цахим төлбөр тооцоо, мөнгөн

гуйвуулга, итгэлцлийн үйлчилгээ, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах болон богино хугацааны санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх зэрэг үйл ажиллагаануудыг эрхлэх бол 1.0 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байхаар тус тус тогтоож байсан байдаг.

Энэ үеэс хойш дорвитой өөрчлөлт ороогүй байсаар, 2015 оны 12 дугаар сард Хорооны 412 дугаар тогтоолоор, тухайлбал зээлийн үйл ажиллагааны хувьд Улаанбаатар хот дахь ББСБ-ын хувьд 0.8 тэрбум төгрөг байхаар тогтоож байсан. Уг тогтоолын хэрэгжилтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хэрэгжүүлж ажиллахыг ББСБ-уудад үүрэг болгосон. Бид ямар ч байсан дээрх 412 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллахад ихээхэн анхаарсан. Улмаар 2016 онд Улаанбаатар хотод банк бус санхүүгийн үйл ажиллагаа шинээр эрхлэх бол 2.5 тэрбум төгрөгөөр, бусад аймаг, сумдад мөн ялгавартай байдлаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоож өгсөн. Үүний дараа уг тогтоолоос өмнө тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхэлж байсан ББСБ-уудыг Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дөрвөн жилийн хугацаанд үе шаттай нэмэгдүүлж, 271 дүгээр тогтоолд заасан хэмжээнд хүргэхийг үүрэг болгосон. Энэ тогтоолын хэрэгжилт сүүлийн хоёр жилд 90 гаруй хувийн биелэлттэй явж байна. Үр дүнд нь салбарын үзүүлэлтэд тодорхой үр дүнгүүд гарсан. Тухайлбал, ББСБ-ын тоо жилд 60–80 орчмоор нэмэгддэг байсан бол одоо харьцангуй тогтвортой болсон. 2016 оны эцэст 518 ББСБ үйл ажиллагаа явуулж байсан бол өнөөдөр 538 ББСБ зах зээлд үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн салбарын нийт хөрөнгийн хэмжээ сүүлийн гурван жилийн туршид жил тутам 30-аас доошгүй хувиар өссөн, харилцагч, зээлдэгч, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, ажилтнуудын тоо ч тогтмол нэмэгдэж байгаа. Түүнчлэн, ББСБ-уудын санхүүгийн эрсдэл даах чадвар нэмэгдсэн зэрэг үр дүнгүүд гараад байна. Товчхондоо, ББСБ-уудын санхүүгийн болон мэргэжлийн чадавх сайжирч, үйл ажиллагааны далайц нэмэгдэж байна.

Технологийн дэвшил маш хурдацтай явагдаж байгаа өнөө үед Монгол Улсад ББСБ-ууд энэ чиглэлд илүү амжилттай ажиллаж байгаа харагдаж байна. Финтекийн хөгжил салбарын бодлогын орчинд хэрхэн нөлөөлж байгаа вэ?

Технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ буюу финтек Монгол Улсад сүүлийн хоёр

жилийн хугацаанд маш хурдацтай хөгжиж байна. ББСБ-ууд энэ чиглэлд түүчээлэн ажиллаж байгаа нь үнэн. Энэ нь санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг иргэдэд амар хялбар байдлаар хүргэх, мөн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж байгаагаараа давуу талтай. Финтекийн хувьд гарааны хөрөнгө оруулалт өндөр байдаг, хугацаа их шаардагддаг учраас зээлийн бүтээгдэхүүний өртөг нь харьцангуй өндөр байна. Цаашид өрсөлдөөн нэмэгдээд, хөрөнгө оруулалтаа нөхөөд эхлэхээр энэ нь буурах боломжтой гэж харж байгаа. Хорооны зүгээс финтекийн чиглэлээр ажиллаж байгаа ББСБ-уудын хяналт, зохицуулалтыг сайжруулахаар ажиллаж байна. Үүнд өнөөдрийн байдлаар ямар нэгэн хүндрэл үүсээгүйг дурдах хэрэгтэй. Ер нь хөгжилтэй орнуудад шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулах арга замыг олох, тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь ард иргэдэд ямар үр өгөөжтэй эсэх, эрсдэлийг тогтоохын тулд sandbox гэсэн зохицуулалтын орчныг бий болгож ажилладаг туршлага байна. Үүнийг мөн хэрэгжүүлж ажиллах шаардлага байгаа.

Сүүлийн үед Хорооноос гаргасан ББСБ-уудын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтын бусад шийдвэрүүдийн талаар мэдээлэл өгөхгүй юу?

2012 онд УИХ-аас баталсан Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн дагуу Хороо уг сангийн өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах болон үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм, журам гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавих эрх, үүрэг хүлээсэн байдаг. Энэ хүрээнд 2019 оны 3 дугаар сард “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлан, мөрдүүлж ажиллаж байна.

Үүнээс гадна “ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулан, олон нийтийн хэлэлцүүлэг хийснээр уг журмыг 2019 оны 7 дугаар сард Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулсан. Журмыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлснээр ББСБ-уудад мөрдүүлэн ажиллаж эхлээд байна. ББСБ-ууд энэ журмаар заасан хязгаарлалт, зохицуулалтад нийцүүлэн 2019 оны 3 дугаар улирлаас санхүүгийн тайлангаа ирүүлэх ёстой.

Мөн дээр дурдсанчлан, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон хяналт шалгалттай холбоотой бодлого,

зохицуулалтыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллаж байгаа.

Таны хувьд ББСБ-ын хөгжлийг хэрхэн төсөөлж байна вэ?

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд ББСБ-ын салбар Монгол Улсын санхүүгийн зах зээлд тодорхой байр суурийг эзэлсэн. Тухайлбал, 2019 оны 2 дугаар улирлын байдлаар гэхэд ББСБ-ын нийт хөрөнгийн хэмжээг арилжааны банкны салбарын нийт хөрөнгөтэй харьцуулахад 4.4 хувь, нийт зээл 5.9 хувьтай байгаа зэрэг үзүүлэлт нь үүнийг илтгэж байна. Одоо финтек, цахим мөнгөний үйлчилгээний чиглэлд томоохон ахиц дэвшлийг авчирсан бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг ард иргэдэд санал болгоод ажиллаж байна. Өмнө дурдсан ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх тогтоолын хэрэгжилт 2021 онд дуусахаар байгаа. Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажилласнаар ББСБ-уудын зах зээлд эзлэх байр суурь, иргэдэд хүргэх санхүүгийн хүртээмж нэмэгдэх, зээлийн хүү буурах боломж нэмэгдэнэ. ББСБ-ууд ч өөрсдөө илүү мэргэжлийн, ёс зүйтэй, санхүүгийн болон боловсон хүчний чадавхтай болон хөгжих бүрэн боломж нээгдэнэ гэж харж байна. Зах зээлийн нийгэм маань өөрөө чөлөөт өрсөлдөөнд суурилсан байдаг болохоор ард иргэдэд хэрэгцээтэй санхүүгийн үйлчилгээг үзүүлээд улам илүү хөгжөөд ажиллах боломж хангалттай бий.

ББСБ-уудын боловсон хүчнийг чадавхжуулах тал дээр Хорооноос ямар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ажилладаг вэ?

Хороо Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой нягт хамтран ажилладаг. Энэ хамтын ажиллагааны хүрээнд ББСБ-ын удирдлагуудыг чадавхжуулах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн онлайн сертификатжуулах сургалтуудыг тогтмол хамтран зохион байгуулан ажиллаж байна. Мөн мэргэжлийн чиглэлийн хэлэлцүүлгүүдийг жил бүр зохион байгуулж ажилладаг. 2019 оны 10 дугаар сард бид Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн найруулах тухай хуулийн төсөл болон бусад асуудлын талаар салбарын оролцогчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулахаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

ББСБ-ын салбарын талаар мэдээлэл өгсөнд баярлалаа.

Баярлалаа.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

1. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАЛАА

Банк бус санхүүгийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, шинэчлэн найруулсан хуулийн төслийг боловсруулсан бөгөөд уг хуулийн төсөлд Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны зөвлөхүүд зөвлөгөө өгч, хамтран ажиллаж байна.

“Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2019–2020 оны төлөвлөгөөний төслийг хамтран боловсруулснаар, Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А109/290/88/44 тоот тушаалаар хөтөлбөрийг баталсан.

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, салбарын үйл ажиллагааг дэмжих нэгдсэн цогц бодлогын хүрээнд 2019 оны эхний хагас жилийн байдлаар дараах журам, заавар, аргачлалыг шинэчлэн баталлаа. Үүнд:

- Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалтыг сайжруулах, холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэх, Хорооноос гарсан шийдвэрүүдийн уялдаа холбоог хангах хүрээнд “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, хяналт тавих журам”-ын төслийг шинэчлэн боловсруулж, Хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлснээр Хорооны 210 дугаар тогтоолоор журмыг баталсан. Энэхүү журмаар зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамааран ялгаатай тооцдог байсныг бүх ББСБ-уудад ижил тогтоохоор, ингэхдээ эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамааран зарим зохистой харьцааг тооцох шаардлагагүйгээр тусгаж өгсөн.
- Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс хамгаалах, батлан даалтын үйлчилгээний хүртээмж, өгөөжийг нэмэгдүүлэх, зайны болон газар дээрх хяналт шалгалтын нарийвчилсан

зохицуулалтыг бий болгох хүрээнд “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ыг 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн 46 дугаар тогтоолоор баталсан. Энэхүү журамд Сангийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг нэмж тусган, Сангийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг оруулж, мэдээ тайлангийн маягуудыг шинэчилсэн.

2. ХОРООНООС БАТАЛСАН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАН АЖИЛЛАЖ БАЙНА

ББСБ-уудын эрсдэл даах чадварыг сайжруулах, үйлчилгээний өртгийг бууруулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, улмаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах нэгдсэн бодлогын хүрээнд Хорооны 2016 оны 271 дүгээр тогтоолоор хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, 2017 оны 27 дугаар тогтоолоор үйл ажиллагаа эрхэлж байсан ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн.

Дээрх тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 2018 онд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байсан 413 ББСБ-аас 221 ББСБ 44.1 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхээс 207 ББСБ 49.6 тэрбум төгрөгөөр, хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байсан 70 ББСБ-аас 35 ББСБ 0.9 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхээс 29 ББСБ 2.5 тэрбум төгрөгөөр, гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй 51 ББСБ-аас 10 ББСБ 11.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлснээр нийт 246 ББСБ 63.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаж ажилласан. Мөн давхардсан тоогоор бусад нэр бүхий 48 ББСБ 59.5 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлснээр 2018 онд Хорооны даргын 372 удаагийн шийдвэрээр нийт 296 ББСБ 123.4 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлсэн байна.

Харин 2019 оны 9 дүгээр сарын байдлаар Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж

байгаа 424 ББСБ-аас 275 ББСБ 104.3 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхээс 229 ББСБ 104.2 тэрбум төгрөгөөр, хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа 69 ББСБ-аас 30 ББСБ 1.1 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхээс 26 ББСБ 1.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлснээр нийт 256 ББСБ 106.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлээд байна. Мөн давхардсан тоогоор бусад нэр бүхий 31 ББСБ 47.5 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлснээр 2019 онд Хорооны даргын 331 удаагийн шийдвэрээр нийт 289 ББСБ 153.1 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлээд байна.

2018 онд хувь нийлүүлсэн хөрөнгө 145.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс 84.8%, 2019 оны 2 дугаар улирлын байдлаар 151.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс 97.5% нь Хорооны 27-р тогтоолын тогтоолын хэрэгжилттэй холбоотойгоор өссөн байна.

3. СУРГАЛТ, СЕМИНАР, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

“Банк бус санхүүгийн байгууллагуудын удирдлагуудыг сертификатжуулах” сургалт амжилттай зохион байгуулагдав

Хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 2.11-т “Тусгай зөвшөөрөл авснаас хойш 6 сарын хугацаанд ББСБ-ын удирдлага нь Монголын банк бус санхүүгийн байгууллагын холбооноос зохион байгуулсан сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна” гэж заасны дагуу сургалтын хөтөлбөрийг боловсруулж, баталсан.

Энэ хүрээнд тус холбооноос “Банк бус санхүүгийн байгууллагуудын удирдлагуудыг сертификатжуулах” сургалтыг 2019 оны 4 дүгээр сарын 24–26-ны өдрүүдэд зохион байгуулж сургалтад нийт 27 ББСБ-ын удирдлага хамрагдсан бол 6 дугаар сарын 12–13-ны өдрүүдэд зохон байгуулагдсан ББСБ-уудын нягтлан бодогч нарт зориулсан сургалтад сургалтад 70 гаруй ББСБ-ын санхүүчид оролцсон байна.

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжүүлэн ажиллаж байна

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Бичил санхүүгийн хөгжлийн сан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв болон аймгуудын Монголбанкны салбар, Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтран зохион байгуулсан “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд цуврал сургалт зохион байгуулагдсан бөгөөд үүний хүрээнд ээлжит сургалт Дорноговь, Өвөрхангай, Архангай, Завхан, Хөвсгөл аймгуудад зохион байгуулагдлаа. Сургалтаар Банк бус санхүүгийн байгууллагын газраас салбарын талаарх танилцуулга, онцлог ба ялгаа, давуу болон сул талууд, зохицуулалт, тавигдах шаардлага болон хууль эрх зүйн орчны талаар танилцуулга хийгдсэн.

Сургалтын үеэр сургалтын үндсэн зорилтот бүлгээс гадна тухайн аймаг, аймгийн төвийн сумдын Засаг даргын тамгын газрын албан хаагчид, Иргэдийн хурлын ажлын албаны ажилтнууд, арилжааны банк, төрийн бусад нэр бүхий байгууллагуудын ажилтан, ажиллагсдад чиглэсэн зорилтот сургалтуудыг

хамтран зохион байгуулж ажиллалаа. Мөн сургалтын хугацаанд Хорооны зохицуулалтын хүрээний байгууллагуудын төлөөлөлтэй нээлттэй хэлэлцүүлэг хийх ажлыг зохион байгуулан ажилласан ба орон нутгийн хэвлэл мэдээллийнхэнтэй уулзалт зохион байгуулж, иргэд олон нийтэд санхүүгийн мэдээллийг хэрхэн ойлгомжтой хүртээмжтэй хүргэх талаар харилцан санал бодлоо солилцож, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ярилцлага, мэдээ өгч ажилласан. Мөн Хорооны холбогдох ажлын хэсгүүд Төв, Хангай, Зүүн болон Говийн бүсийн аймгуудаар санхүүгийн зах зээлийг сурталчлах, мөнгө угаах болон терроризмтэй тэмцэх, комплаенсын чиглэлээрх ээлжит сургалт, хэлэлцүүлгийг зохицуулалттай этгээдүүд болон олон нийтэд зориулан зохион байгууллаа.

Бусад хамтын ажиллагаа

ББСБ-ын удридлагууд болон ажилтнуудад банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай мэдлэг, мэдээллийг нэг дороос, цогц байдлаар олгох, Хорооноос гаргасан эрх зүйн акт, тэдгээрийн нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээлэл өгөх зорилго бүхий “Сургалт зохион байгуулах гэрээ”-г

Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга болон Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны ерөнхийлөгч нар 2019 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 04-10 дугаартай гэрээгээр үзэглэсэн. Үүний дагуу 6 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн 3 ээлжээр явагдсан “Комплаенс ба ёс зүй” цахим сургалтад 230 ББСБ-ын 315 ажилтан хамрагдсан.

Санхүүгийн зохицуулах хороо, Гадаад харилцааны яам болон Монголын финтекийн холбоо хамтран зохион байгуулсан “Финтек frontier” форум болон Гадаад харилцааны яам, Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, Бүгд Найрамдах Польш Улсын Гадаад хэргийн яам, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай хамтран зохион байгуулсан “Монгол Улсын жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлогод дэмжлэг үзүүлэх нь” сэдэвт семинар зэрэгт салбартай холбоотой мэдээ, мэдээллийг өгч хамтран ажиллалаа.

Мөн Монголбанк, Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо, Олон улсын санхүүгийн корпорациас хамтран зохион байгуулсан “Ногоон таксономи” семинар, хэлэлцүүлэгт оролцлоо.

ББСБ-ЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ТҮҮХЭН ЗАМНАЛ

Манай орны нийгэм, эдийн засгийн тогтолцоог зах зээлийн сонгодог харилцаанд шилжүүлэх талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд 1990-ээд оны дунд үеэс эдийн засаг, нийгмийн харилцаанд томоохон өөрчлөлтүүд гарсан билээ.

Эдгээр өөрчлөлтүүдийн нөлөөгөөр үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашиг, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул учруулж болзошгүй үйл ажиллагааг хянах, аливаа ноцтой зөрчил, хор уршгаас урьдчилан сэргийлэх, түүнчлэн эдийн засгийг дэмжих, нийтийн хязгаарлагдмал баялаг, нөөцийг хуваарилах, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг 2001 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хурлаас баталсан билээ. Уг хуулиас гадна банк, даатгал, үнэт цаас, хадгаламж, зээлийн хоршоо болон банк бус санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой

салбарын шинжтэй хууль тогтоомж, олон улсын зарим гэрээгээр зөвшөөрөл олгох харилцааг нарийвчлан зохицуулсан байдаг.

Үүний нэг тод жишээ нь шинээр үүссэн санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох, цаашид хөгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлаас 2002 онд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг батлан гаргасан явдал бөгөөд уг хууль батлагдсанаар Монгол Улсад ББСБ-уудын системтэй хөгжлийн гарааны үндсэн суурь тавигдсан юм.

1996-1997 онд 3 банк хаагдсантай холбоотойгоор банк санхүүгийн салбарт итгэх олны итгэл ихээхэн буурч уг салбар ерөнхийдөө сул байдалд байлаа. Олгож буй зээл нь өндөр хүүтэй, богино хугацаатай байсан бөгөөд гол төлөв том аж ахуйн нэгжид зээл олгогдож байсан юм. Жижиг бизнест, нэн ялангуяа Улаанбаатараас бусад хот, хөдөө орон нутагт нэн шаардлагатай

зээлийн хэрэгцээг банк санхүүгийн салбар төдийлөн хангаж чадахгүй байсан тул үүссэн энэ цоорхойг бөглөх цоо шинэ альтернатив ББСБ-ыг үүсгэн байгуулах санаа төржээ (*Эх сурвалж: Монгол дахь бичил санхүүгийн дэд салбарын судалгаа – 2005, НҮБХХ*).

Энэ утгаараа, иргэд, аж ахуйн нэгжүүдэд банкны эрхэлж буй санхүүгийн зарим үйлчилгээг шуурхай хүргэх, иргэдэд төдийлөн хүрч чаддаггүй бичил, жижиг зээлийн томоохон орон зайг нөхөх, санхүүгийн зуучлалын хүрээг өргөтгөх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилго бүхий банк бус санхүүгийн үйлчилгээ 1990-ээд сүүлчээр бий болж эхэлсэн түүхтэй.

2002 онд батлагдсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд энэ хугацаанд зарим хуулинд орсон нэмэлт өөрчлөлт, шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хуулиудтай холбоотойгоор нийт

есөн удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байдаг.

Улсын Их Хурлаас 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг баталснаар ББСБ-уудын үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалтын чиг үүрэг Монголбанкнаас Санхүүгийн зохицуулах хороонд шилжих эрх зүйн орчин бүрдэж, улмаар Улсын Их Хурлын 2006 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Хороо байгуулагдсанаар банк бус санхүүгийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлж эхэлсэн түүхтэй.

Хороо нь 2006 оноос хойш ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх тухай таван удаагийн шийдвэрийг гаргаж байсан бөгөөд тус салбарын үйл ажиллагааны зохицуулалтын журам, үйл ажиллагааны зохистой харьцаатай холбоотой журам болон бусад холбогдох журмуудыг тухай бүр шинэчлэн болон шинээр батлан, мөрдүүлэх зэргээр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тухайлбал, 2007 оны 12 дугаар сараас валют солих цэгүүдийн үйл ажиллагаа нь тус Хорооны хяналт, зохицуулалтын хүрээнд хамрагдах болсонтой холбогдуулан уг салбарын зохицуулалтын журмыг шинээр баталж, зөвхөн улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдэд валют солих цэгийн зөвшөөрөл олгож, өмнө нь Монголбанкнаас зөвшөөрөлтэй байсан боловч тус Хорооны зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлж байсан иргэн, хуулийн этгээдийн валют солих цэг ажиллуулах зөвшөөрлийг хүчингүй болгож байсан. Улмаар, валют солих цэгийг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн хүрээнд үйл ажиллагааг явуулахаар зохицуулж, нөхцөл шаардлагыг хангасан хуулийн этгээдэд зөвхөн гадаад валютын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож эхэлсэн.

Мөн олон улсын санхүүгийн зах зээл дэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хороо нь венчур хөрөнгө оруулалт, цахим мөнгөний үйлчилгээ, зээлийн батлан даалтын үйлчилгээний журмуудыг тус тус шинээр батлан мөрдүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байсан билээ. Эдгээр журмуудыг батлан, мөрдүүлж ажилласнаар венчур хөрөнгө оруулалтын хувьд боломжит хөрөнгө оруулагчид болоод бизнесийн шинэлэг төсөл хэрэгжүүлэгчдэд үнэ цэнээ өгөх, цахим мөнгөний үйлчилгээний хувьд гар утасны дугаараар үүссэн цахим мөнгөний дансаар дамжуулан бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээ, бараа, үйлчилгээ худалдан авалт, мөнгөн шилжүүлэг зэрэг үйлчилгээнд хамрагдах, зээлийн батлан даалтын үйлчилгээний хувьд жижиг, дунд үйлдвэрийн эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, тэдгээрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, шинээр ажлын байр бий болгох үйл ажиллагааг дэмжихэд санхүүгийн шинэ хэрэгсэл, механизм бүрэлдэхэд чухал ач холбогдлоо өгсөн юм.

Он цагийн онцлох үйл явдал

2002 он: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль батлагдав.

2003 он: Монголбанк ББСБ-ын хяналт, зохицуулалтыг хариуцсан анхны бие даасан нэгж “Банк бус санхүүгийн байгууллагын хэлтэс”-ийг шинээр байгуулав.

2005 он: Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль батлагдаж, ББСБ-уудын үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалтын чиг үүрэг Монголбанкнаас Хороонд шилжих эрх зүйн орчин бүрдэв.

2006 он: УИХ-ын 10 дугаар тогтоолоор анхны удирдлага томилогдон Санхүүгийн зохицуулах хороо үйл ажиллагаагаа

эхлүүлснээр ББСБ-ын үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлж эхлэв.

2007 он: Монголбанкнаас тусгай зөвшөөрөл олгогдсон ББСБ-уудын тусгай зөвшөөрлүүдийг Хорооны шийдвэрээр шинэчлэн олгов.

2008 он: Валют солих цэгүүдийн үйл ажиллагаа нь Хорооны хяналт, зохицуулалтын хүрээнд хамрагдахаар болсноор 25 цэгийн зөвшөөрлийн гэрчилгээг шинэчлэн олгов.

2009 он: Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуультай нийцүүлж гадаад валютын арилжааг тусгай зөвшөөрлийн хүрээнд ББСБ эрхэлж байхаар зохицуулав.

Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн цахим мөнгөний үйлчилгээг банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэхээр зохицуулав.

2010 он: Бичил санхүүгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Монголбанкны Зээлийн мэдээллийн санд зээлдэгчдийн талаарх мэдээллийг нийлүүлэх, холбогдох мэдээллийг авахад ашиглах “Монголбанкны Зээлийн мэдээллийн санд өгөгдөл дамжуулах Micro finance” програм хангамжийг бий болгож, Зээлийн мэдээллийн санд ББСБ-ын мэдээллийг цуглуулах боломж нээгдэв.

2011 он: Монголбанкны Зээлийн мэдээллийн санд зээлдэгчдийн талаарх мэдээллийг нийлүүлэх, холбогдох мэдээллийг авахад ашиглах “Монголбанкны Зээлийн мэдээллийн санд өгөгдөл дамжуулах Micro finance” програм хангамжийн гарын авлагыг цахим хуудсанд байршуулав.

2012 он: Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар “Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг батлагдав.

2013 он: ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгодог болов.

2014 он: “Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй бараа, үйлчилгээнд татвар ногдуулах тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж батлуулснаар гадаад валютын арилжааг зөвхөн тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх эрх зүйн баримт бичиг баталгаажигдав.

2015 он: ББСБ-ын үйл ажиллагаанд арилжааны банканд зориулсан журмыг мөрдүүлж байсныг зогсоож, үйл ажиллагааны онцлог, эрсдэлтэй нь уялдуулан Хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан тушаалаар “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг шинээр батлан, мөрдүүлж эхлэв.

2016 он: Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэн 2.5 тэрбум төгрөгөөр шинэчлэн тогтоож, ББСБ-ын зээлийн хүүг 2020 оны эцэс гэхэд хоёр дахин бууруулах бодлогын зорилтоо зарлав.

2017 он: ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг газар зүйн байршлаас хамааруулан ялгавартай байхаар шинэчлэн тогтоов.

2018 он: Хорооны 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 60

дугаар тогтоолоор “ЛэндМН ББСБ” ХК-ийн нэг бүр нь 25 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 800 сая ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэв. 02 дугаар сарын 21-ний өдрөөс 3 дугаар сарын 07-ны өдрийг хүртэлх хугацаанд анхдагч зах зээлийн арилжааны захиалга хийгдсэн бол 3 дугаар сарын 14-ний өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

2019 он: Хорооны 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 03 дугаар тогтоолоор “Ард кредит ББСБ” ХК-ийн нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 280 сая ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэв. 02 дугаар сарын 18-ны өдрөөс 3

дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд анхдагч зах зээлийн арилжааны захиалга хийгдсэн бол 3 дугаар сарын 11-ний өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

Хорооны 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 70 дугаар тогтоолоор “Инвекор ББСБ” ХК-ийн нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 71.7 сая ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэв. 5 дугаар сарын 22-ны өдрөөс 30-ны өдрийг хүртэлх хугацаанд анхдагч зах зээлийн арилжааны захиалга хийгдсэн бол 6 дугаар 10-ны өдрөөс эхлэн хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУЛТ, ХАРИУЛТ

Факторинг гэж юу вэ?

Бизнесийн байгууллага, иргэн өөрийн үзүүлсэн бараа үйлчилгээний төлбөрийг хүссэн хугацаандаа авч эргэлтэнд оруулж чадахгүйгээс ихээхэн хүндрэлд ордог бөгөөд энэхүү хүндрэлээс гарахын тулд санхүүгийн зах зээл өндөр хөгжсөн орнуудад авсан арга хэмжээний нэг нь факторингийн үйлчилгээ юм. Факторингийн үйлчилгээ нь томоохон компаниудаас илүүтэйгээр жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хамгийн тохиромжтой үйлчилгээ юм.

“Факторинг” нь “factor” гэсэн англи үгнээс гаралтай бөгөөд бэлтгэн нийлүүлэгч нь борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг шаардах эрхээ факторингийн компанид шилжүүлсний үндсэн дээр фактороос бүтээгдэхүүн нийлүүлэгчид олгох санхүүжилтийн үйлчилгээг “факторингийн үйлчилгээ” гэж ойлгож болно.

Факторингийн үйлчилгээний хууль эрх зүйн зохицуулалт нь юу вэ?

Монгол Улсын Иргэний хуулийн 123 дугаар зүйлд шаардах эрхээ шилжүүлэхтэй холбоотой ерөнхий харилцааг зохицуулж өгсөн бөгөөд 2002 онд батлагдсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулиар факторингийн үйлчилгээ нь санхүүгийн үйлчилгээний нэг төрөл байхаар, Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан ББСБ нь энэхүү үйлчилгээг эрхлэхээр нарийвчлан зохицуулсан.

Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “факторингийн үйлчилгээ” гэж зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах /шилжүүлэх/,

энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүрэн хариуцах үйл ажиллагааг ойлгоно гэж тодорхойлсон.

Факторингийн үйлчилгээ нь ямар процессоор дамждаг вэ?

1. Худалдагч тал нь бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авагчид хүргүүлэх ба төлбөрийг хийх хугацааг тохирно;
2. Худалдагч нь худалдан авагчаас бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг нэхэмжлэх эрхийг факторингийн

үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлнэ;

3. Факторингийн үйлчилгээ үзүүлэгч нь бэлтгэн нийлүүлсэн бараа бүтээгдэхүүний үнийн тодорхой хэсгийг худалдагчид шилжүүлнэ;
4. Худалдан авагчийн зүгээс бараа, бүтээгдэхүүний үнийг факторингийн үйлчилгээ үзүүлэгчид үнийг төлнө;
5. Факторингийн үйлчилгээ үзүүлэгч нь үлдэгдэл төлбөрийг худалдагчид шилжүүлэх ба өөрийн үйлчилгээний шимтгэлийг суутган авна.



Факторингийн үйлчилгээний үр өгөөж нь юу вэ?

- Авлагын хэмжээ буурч, төлбөрийн чадварыг сайжруулна;
- Зах зээлд эзлэх байр суурь өсч, бизнесийн цар хүрээ тэлнэ;
- Өр төлбөр буурах ба бэлтгэн нийлүүлэгчээс хөнгөлөлт эдлэх боломжтой;
- Бэлэн мөнгөний эргэц сайжирна;
- Татвар болон бусад үүргийг хугацаанд нь биелүүлнэ;
- Худалдааны эргэлт ба ашгийн хувь хэмжээ өснө;
- Саатаж буй мөнгөн хөрөнгийг чөлөөлж борлуулалтыг зах зээлд оруулна.

Итгэлцэл гэж юу вэ?

Иргэн, хуулийн этгээд өөрийн актив хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, үр шим хүртэх зорилгоор ББСБ-тай харилцан тохиролцон хэлцэл хийх бөгөөд ББСБ нь хөрөнгийг удирдах, тэдгээрийн нэрийн өмнөөс захиран зарцуулах үүрэг хүлээх эрхийн харилцааг итгэлцлийн үйлчилгээ гэж ойлгоно.

Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ, мөнгөн хадгаламж хоёрын ялгаа?

Хадгаламжийн гэрээгээр хадгалуулагч иргэн, хуулийн этгээд мөнгөн хөрөнгөө тодорхой хугацаагаар, эсвэл хугацаагүйгээр хадгалуулах, банк, эрх бүхий хуулийн этгээд нь уг мөнгийг гэрээнд заасан хугацаанд хадгалж, тохиролцсон хэмжээгээр хүү төлөх, эргүүлэн олгох үүргийг харилцан хүлээдэг үйл ажиллагаа бол итгэлцлийн үйлчилгээ нь итгэмжлүүлэгч буюу иргэн, хуулийн этгээдийн тодорхой нэр төрлийн активыг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр захиран зарцуулж, хугацааны эцэст тодорхой үр шим амладаг үйл ажиллагаа юм. Итгэлцлийн үр шимийг нийтэд зарладаггүйгээрээ онцлог.

ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлэх хөрөнгөд хязгаарлалт байдаг уу?

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох журмаар ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь өөрийн хөрөнгийн 80 хувиас ихгүй байхаар тогтоосон.

Итгэлцлийн үр шимийг нэрлэсэн хувь хэмжээгээр тооцож болох уу?

Итгэлцлийн үр шимийг нэрлэсэн хувь хэмжээгээр тооцож болохгүй ба харин үр шимийг аккрузл сууриар хуримтлуулан бүртгэнэ.

БУСАД ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

ББСБ-ын онцлог шинж, давуу тал?

Банк болон хадгаламж зээлийн, хоршоодын хөрөнгийн голлох эх үүсвэр нь иргэд, аж ахуйн нэгж, гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламж байдаг бол ББСБ-уудын хөрөнгийн гол эх үүсвэр нь үүсгэн байгуулагч/хувьцаа эзэмшигчдээс оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгө байдаг. Өөрөөр хэлбэл, ББСБ-уудын дийлэнх хувь нь өөрийн хөрөнгөдөө тулгуурлан үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг тул харилцагч иргэн, аж ахуйн нэгжид учруулах эрсдэл харьцангуй бага байдаг онцлогтой.

Банкнаас тавигддаг нөхцөл, шаардлагыг хангах боломжгүйгээс үйлчилгээ бүрэн авч чадахгүй байгаа иргэн, аж ахуйн нэгжид жижиг, дунд хэмжээний зээлийн үйлчилгээг харьцангуй түргэн шуурхай үзүүлдэг бөгөөд бизнес эрхлэгчдийн бичил зээлийн гэнэтийн хэрэгцээг шуурхай хангах бололцоотой юм.

Үйл ажиллагааны тусгайлсан хууль эрх зүйн зохицуулалттай, ББСБ-уудын бизнесийн болон үйл ажиллагаанд үүсч болзошгүй эрсдэлийг хянах, хөрөнгө оруулагч, харилцагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс төрийн хяналт зохицуулалтад байдаг.

"Банкны үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байгаа иргэн" гэж хэнийг ойлгох вэ?

Банкнаас тодорхой хэмжээний үйлчилгээг авдаг боловч, банкны үйлчилгээг бүрэн авч чаддаггүй иргэнийг ойлгоно.

ББСБ-аар үйлчлүүлэхдээ юуг анхаарвал зохих вэ?

Эн тэргүүнд тухайн байгууллага нь Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан эсэхийг нягтлах, тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэхийг тодруулах, үйл ажиллагаа явуулсан туршлага, боловсон хүчний мэдлэг чадвар, ажлын байрны тоног төхөөрөмжтэй эсэхийг мэдвэл зохихоос гадна тухайн ББСБ нь жил бүр аудитын байгууллагаар баталгаажуулж хянуулсан санхүүгийн тайлангаа нийтэд мэдээлэх үүрэгтэй бөгөөд энэхүү тайлангаас санхүүгийн байдал, хөрөнгийн чадавхийг харах нь зүйтэй.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд хадгаламж татаж болох уу?

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 12.1.3-т "иргэн хуулийн этгээдээс хадгаламж авах, хадгаламжийн данс нээх" 12.1.4-т "чек, карт, вексель зэрэг төлбөрийн хэрэгслээр хадгаламж авахыг хориглоно"

гэж заасан байдаг тул болохгүй.

ББСБ-ын хувьд эх үүсвэрээ нэмэгдүүлэх ямар боломжууд байдаг вэ?

Банк, санхүүгийн байгууллагын урт болон богино хугацаат зээлийн эх үүсвэр, төслийн зээлийн санхүүжилт, итгэлцлийн үйлчилгээ, хаалттай өрийн бичиг гаргах, хоёрдогч өглөг татах замаар тодорхой хязгаарлалтын хүрээнд эх үүсвэрээ нэмэгдүүлэх боломжтой.

Өрийн бичиг /бонд/ гэж юу вэ?

Тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн эсвэл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаасыг хэлэх бөгөөд ББСБ нь өөрийн хөрөнгийн 50 хүртэлх хувиар хаалттай өрийн бичиг гаргах боломжтой.

Хоёрдогч өглөг гэж юу вэ?

Гэрээнд заасан хугацаа дууссаны эцэст хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаагаар солих бөгөөд энэ талаар холбогдох гэрээнд тодорхой заасан байх өрийн бичгийг хэлэх ба уг эх үүсвэр нь өөрийн хөрөнгөд бүртгэгддэг.

ББСБ-уудын хувьд хувьцаанд хөрөнгө оруулалт хийж болох уу?

Тодорхой хязгаарлалтын хүрээнд арилжааны үнэт цаас, хөрөнгө оруулалтын үнэт цаас зэрэг богино хугацаат санхүүгийн хэрэгслэд хөрөнгө оруулалт хийж болох ба энэ тохиолдолд Хорооноос зохих тусгай зөвшөөрлийг авсан байх шаардлагатай.

ББСБ нь санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхэлж болох уу?

ББСБ нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулиар зөвшөөрсөн 10 нэр төрлийн үйл ажиллагааг эрхэлж болох бөгөөд үүнд санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа хамаардаггүй.

Барьцаалан зээлдүүлэх газар Санхүүгийн зохицуулах хорооны хяналт зохицуулалтад хамаардаг уу?

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулиар тус Хорооны бүрэн эрхийг тодорхойлж өгсөн байдаг бөгөөд үүнд барьцаалан зээлдүүлэх газар хамаардаггүй.

Бизнес төлөвлөгөө гэж юуг ойлгох вэ? Түүний ач холбогдол юунд оршдог вэ?

Байгууллага зорилгодоо хүрэх арга хэмжээнүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр урьдчилан боловсруулж, эрх бүхий этгээдийн баталсан баримт бичиг, удирдамж юм. Бизнес төлөвлөгөө нь үйл ажиллагаагаа хянах, үнэлэх, сайжруулах арга

хэрэгсэл болдог.

“Бичил зээлдэгч” гэж хэнийг хэлэх вэ?

Тухайн улсын амьжиргааны түвшний жишгээр тогтоогдсон бичил зээлийн хэмжээнд зээл авч буй этгээд буюу бага дүн бүхий мөнгийг бага хэмжээний барьцаа/ баталгаатайгаар зээлсэн, бичил бизнес эрхлэгч хамаарна.

“Бичил санхүү” гэж юуг ойлгох вэ?

Эмзэг, орлого багатай иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ирээдүйд бий болох эрсдэлээс хамгаалахын тулд тэдгээрийн боломж, хэрэгцээнд нийцсэн санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээг холбогдох сургалт, зөвлөх үйлчилгээний хамт хүртээмжтэйгээр хүргэдэг санхүүгийн үйлчилгээ юм. Бичил санхүү нь барьцаа хөрөнгийн дутагдалтай, орлого багатай этгээдэд зээлийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ тэдэнд бичил хадгаламжтай болох, бичил даатгалын үйлчилгээнд хамрагдах, төлбөр тооцооны хэрэгсэл ашиглан гүйлгээ хийх боломжийг олгодог.

Зах зээлийн хүүг хэрхэн тооцдог вэ?

Эрэлт, нийлүүлэлтийн үндсэн дээр тогтоогдсон зах зээл дээр зонхилж буй хүү бөгөөд хугацаа, хэмжээ, эрсдэлийн түвшингээс хамааран ялгаатай байдлаар тогтоогддог.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хэн тогтоодог вэ?

Санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа болон санхүүгийн нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас тогтоож, мөрдүүлдэг санхүүгийн харьцааны үзүүлэлт юм.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлс” гэж юуг хэлэх вэ?

Төрөөс зохицуулалтын үйлчилгээ үзүүлж буйн хариуд тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс, батлагдсан аргачлалын дагуу жил бүр эсвэл тухай бүр тусгай дансанд төвлөрүүлэн авдаг хураамж юм.

“Зээл эргэн төлөх чадвар” гэж юуг ойлгох вэ?

Зээлдэгч орлогоороо зээлийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлснөөр зээлдэгчийн

санхүү, төлбөрийн чадварын хэвийн байдлыг алдагдуулахгүй байх чадварыг хэлнэ.

“Санхүүгийн үйлчилгээний хүртээмж” гэж ямар ойлголтыг хэлэх вэ?

Санхүүгийн үйлчилгээ авах боломжгүй, санхүүгийн мэдлэг дутмаг байгаа хүн амын хэсэг уг үйлчилгээнд хамрагдаж байгаа эсэхийг тодорхойлох хэмжүүр юм.

“Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар” /хөрвөх чадвар/-ыг хэрхэн тооцдог вэ?

Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө болон бусад төлбөрийн нэхэмжлэлийг анхны шаардлагаар гүйцэтгэх чадамжаар тодорхойлогдоно.

“Улсын тэмдэгтийн хураамж” гэж юуг ойлгох вэ?

Төрийн зохих байгууллагаас эрх олгох, эрх шилжихтэй холбогдсон баримт бичиг олгох буюу бүртгэх, гэрээ хэлцэл, баримт бичгийг батлан гэрчлэх, иргэний бүртгэл хийх, шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлсний төлөө зохих этгээдээс төлж байгаа мөнгөн хөрөнгийг ойлгоно.

ФИНТЕК БА РЭГТЕК

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХҮРТЭЭМЖ: ФИНТЕКИЙН ӨНӨӨГИЙН ОРЧИН, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ

Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, тэгш бус байдал ядуурлыг бууруулах нь олон улс орны бодлого гаргагчдын хувьд чухал зорилтууд байдаг. Уг хоёр зорилтод зэрэг хүрч чадаж байвал тухайн улс санхүүгийн зах зээлийн хүртээмжтэй өсөлтийг бий болгож байна гэсэн үг юм.

Санхүүгийн зах зээлийн хүртээмжийн өсөлтөд хүргэх гол шийдэл нь “инноваци” болоод байна. Учир нь инноваци хүн амын ядуу хэсэг буюу санхүүгийн үйлчилгээг хүртэж чадаагүй иргэдийг хамарч, тэдний амьдралд дэвшил авчирч чадахуйц байвал бид үүнийг хүртээмжтэй инноваци гэж нэрлэдэг. Хүртээмжтэй инноваци нь хүртээмжтэй өсөлтийг бий болгодог.

Инновацийн үр дүнд бий болж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийн дэвшил нь зах зээл дэх өрсөлдөөнийг дэмжиж, зардлыг бууруулан, үр ашгийг нэмэгдүүлдэг бөгөөд инновацийн зах зээлд

нөлөөлж буй цар хүрээ нийгмийн бүхий л бүлгийн хүн бүрийн амьдралд дэвшил авчирхуйц хүртээмжтэй байх ёстой гэдэг зарчим нь хамгийн чухал асуудал юм.

Сүүлийн жилүүдэд мэдээлэл технологийн салбарт шинээр гарч буй инновациуд нь хүртээмжтэй инновацийн маш том жишээ болоод байна. Үүгээр дамжуулан зах зээлийн хөгжлөөс алслагдсан иргэдэд гар утас, интернетийн сүлжээг нэвтрүүлснээр хөгжлийн наад захын амин чухал хэрэгцээ болох эрүүл мэнд, боловсрол, банк санхүүгийн үйлчилгээг хүргэх боломж нээгдэж байна.

Энэ дундаа санхүүгийн зах зээлд гарч буй инноваци нь зах зээлийн хэмжээг нэмэгдүүлж, гүнзгийрүүлж, төрөлжүүлж, глобалчилж, тэр ч бүү хэл санхүүгийн зах зээлийн бүтцийг өөрчилж, санхүүгийн системийг улам боловсронгуй болгон хүртээмжтэй өсөлтийг бий болгож байна. Технологийн дэвшилд суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ буюу финтек нь албан ёсны санхүүгийн зах зээлийн гадна орхигдсон маш олон хүмүүст санхүүгийн

үйлчилгээг хүргэж, хүртээмжийг нэвтрүүлж байгаа сайн жишээнүүд дэлхий нийтэд маш олон бий.

Тухайлбал, финтекийн бүтээгдэхүүн үйлчилгээнүүдээр дамжин санхүүгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлснээр тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх боломж өсөж байна. Ядуучуудад туслах зөвлөлдөх бүлэг /CGAP/-ээс гаргасан судалгаанаас үзэхэд санхүүгийн хүртээмж нэмэгдсэнээр дараах тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх боломжтой юм. Үүнд:

- *Ядуурлыг бууруулах:* Дижитал санхүүгийн системийн тусламжтайгаар ядуу, алслагдсан газар нутагт амьдардаг өрх гэрүүд хамаатан садан, найз нөхдөөсөө мөнгөн тусламж авах боломж нэмэгдэж байгаа бөгөөд Засгийн газраас ядуурлын эсрэг хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр мөнгөн тусламжийг зорилтот бүлэгт шууд хүргэх боломж нэмэгдэж байна.
- *Өлсгөлөнг бууруулж хүнсний аюулгүй байдлыг хангах:* Дижитал санхүүгийн бүтээгдэхүүн нь мал аж ахуй, газар

тариалан эрхлэгчдэд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэр дундаа даатгалын үйлчилгээг хүргэснээр ургац хураалтын гэнэтийн алдагдлыг нөхөж байна.


- **Хүн амын эрүүл мэнд болон сайн сайхан байдлыг дээшлүүлэх:** Дижитал санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан иргэд эрүүл мэндийн даатгалд хамрагдах, гар утасны хэтэвчиндээ эрүүл мэндийн зардалд зориулсан хадгаламжийг амар хялбараар хуримтлуулах зэрэг давуу талууд үүсэж байна.
- **Боловсролын чанарыг сайжруулах:** Дижитал мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглан финтек компаниуд боловсролын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж эхэлсэн ба тус үйлчилгээг ашиглан сургалтын төлбөрөө шууд сургууль руугаа шилжүүлэх боломжтой болж эхэлсэн.
- **Жендерийн тэгш бус байдлыг бууруулах:** Дижитал санхүүгийн үйлчилгээ нь эмэгтэйчүүдийн бэлэн мөнгөнөөс шалтгаалсан гэмт хэргийн золиос болох эрсдэлийг бууруулж, гэрээсээ хол ажиллах, мөнгөн шилжүүлэг амар хялбар

хийх боломжийг нэмэгдүүлснээс гадна, өрх гэрийн өдөр тутмын завгүй ажлын хажуугаар санхүүгийн үйлчилгээ авах, шилжүүлэг хийх зэрэгт зарцуулах хугацааг багасган, санхүүгийн үйлчилгээг идэвхтэй ашиглах, бизнес эрхлэх сонирхлыг нэмэгдүүлж байна.


Дээрх тогтвортой хөгжлийн зорилтууд болон хүн амын сайн сайхан байдалд оруулж буй хувь нэмрээс нь үзэхэд санхүүгийн инноваци нь нийгэмд өөрчлөлт авчирхуйц биет болон биет бус хөрөнгийг бүтээж, хөгжиж буй болон өндөр хөгжилтэй орнуудын тэгш бус мэдээлэл, өрсөлдөөний ялгааг бууруулан, нийгмийн хүртээмжийг сайжруулж тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулж байна. Товчоор хэлбэл, санхүүгийн салбар болон тогтвортой хөгжлийн гүүр нь санхүүгийн инноваци болж байна.

Дэлхий дахинд 2018 оны байдлаар нийт насанд хүрэгчдийн 31 хувь буюу 1.7 тэрбум хүн санхүүгийн үйлчилгээг хүртэж чадахгүй байна. Үүнээс 51 хувь нь эрэгтэй, 49 хувь нь эмэгтэй байна. Насаар ангилбал, 17–24 насныхан 23 хувь байгаа бол 24–өөс дээш насныхан 77 хувийг эзэлж байна.


Зураг: Нийт зээл




Зураг: Нийт зах зээлд эзлэх хувь




Зураг: Нийт харилцагчид



Зураг: Нийт зээлдэгчид



Зураг: Санхүүгийн үйлчилгээ хүртэж чадахгүй хүн амын хувь, бүсээр



Эх сурвалж: Дэлхийн санхүүгийн хүртээмжийн мэдээллийн сан, Дэлхийн банк, 2018 он

Дэлхийн хэмжээнд финтек компаниудын нийт хөрөнгийн хэмжээ нь 2018 оны байдлаар 52.4 тэрбум ам.доллар буюу санхүүгийн зах зээлийн 4.1 хувийг л эзэлж байна.

Монгол улсын хувьд финтек компаниудын нийт зээлийн үлдэгдэл нь зах зээлийн нийт зээлийн үлдэгдлийн 4.5 хувь буюу 38.8 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Харин Монгол Улсын хэмжээнд 2019 оны 2 дугаар улирлын байдлаар нийт хүн амын 66 хувь нь финтекийн үйлчилгээ авч байгаа юм. Мөн ББСБ-ын нийт 2.3 сая харилцагчдын 91 хувь нь финтекийн үйлчилгээ хэрэглэж байгаа бол 360.3 мянган зээлдэгчдийн 63 хувь нь финтекийн үйлчилгээ хэрэглэж байна.

ОЛОН УЛСЫН ЖИШЭЭ: САЯ САЯ ХҮМҮҮСТ САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ ХҮРГЭХ ГАР УТАСНЫ ТЕХНОЛОГИ /АФРИК ТИВ/

Африк тив бол дэлхийн гар утасны хамгийн хурдацтай хөгжиж буй санхүүгийн зах зээлийн талбар юм. Уг тивд уламжлалт банкны салбар болон АТМ-ны тоо багатай тул гар утас нь хэдэн зуун сая африкчуудад санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх боломжийг олгодог байна. Үүний зэрэгцээ, ирэх 25 жилийн дотор хоёр дахин нэмэгдэх гэж байгаа Африкийн залуу хүн ам нь бусад улс орны хүмүүстэй харьцуулахад гар утсанд суурилсан санхүүгийн үйлчилгээг илүү ихээр ашиглах хандлага ажиглагдаж байна.

Гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээ үзүүлдэг гар утасны Польш улсаас гаралтай “Zenka Finance” компани нь Африкт өөрсдийн брэндээ гаргахаар хичээн ажиллаж байгаа юм. Zenka Finance нь 2018 оны 12 дугаар сараас Кени улсад үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба жижиг бизнес эрхлэгчид болон энгийн хэрэглэгчдэд чиглэсэн 5 ам.доллараас 200 ам.доллар хүртэлх хэмжээтэй гар утасны бичил зээлийг санал болгосон.

2018 оны FinAccess судалгаагаар дижитал зээлийг хамгийн ихээр бизнесийн хэрэгцээнд ашигладаг болохыг харуулсан ба Zenka Finance нь уг хэрэгцээг тодорхойлж, бизнесийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйлчилгээг бий болгох, хүртээмжтэй хүргэх арга замыг эрэлхийлсэн байна. Юуны өмнө, Zenka Finance-ийн зээлийн бүтээгдэхүүн нь маш уян хатан бөгөөд үйлчлүүлэгч нь өөрийн хэрэгцээ шаардлагаасаа хамааран нэгээс 30 хоногоор төлөх хугацаагаа уртасган, зээлийн хязгаартаа багтаан нэмэлт мөнгө авах хүсэлт гаргах боломжтой.

Zenka Finance-ийн Кенийн зах зээлд хэрэгжүүлсэн бас нэг өвөрмөц онцлог зүйл бол анх удаа зээл авч буй зээлдэгчдэд анхны зээлээ ямар ч шимтгэлгүйгээр авах боломжийг олгосон явдал юм. Мөн зээлүүд

нь хэрэглэгч бүрт хялбар байдаг. Android болон IOS үйлдлийн системтэй утасны Google Play Store болон App Store дээрээс бүрэн татаж авч ашиглах боломжтой, түүнчлэн USSD *841# кодоор дамжуулан үйлчилгээгээ авах боломжтой юм. Энэхүү кодоор дамжуулах арга нь хөдөө орон нутгийн гар утасны аппликейшн ашиглах боломжгүй, ухаалаг гар утасгүй бичил болон жижиг бизнес эрхлэгчдэд тохиромжтой.

Үүнээс гадна Zenka Finance нь харилцагчиддаа анхаарал халамж тавих, туршлага хуримтлуулах зэрэгт ихээхэн хөрөнгө оруулалт хийжээ. Энэ ажлын хүрээнд үйлчлүүлэгчийн лавлагааг тусгай мэргэжилтний багаар бүрдүүлсэн ба AI-ийн хүчирхэг CC системээр шуурхай удирддаг байна.

Үйлчлүүлэгчдийн санхүүгийн аюулгүй байдлыг хангахын тулд Zenka нь машин тооцооллын алгоритм, зээлийн мэдээллийн сангийн хэрэглээ, хуурамч гэмт хэрэгтэй тэмцэх аргачлал, эдийн засагт суурилсан онооны загвараар хэрэглэгчдийг тодорхойлох, зээлийн чадварыг үнэлэх нарийн төвөгтэй хэрэгсэл зэргийг боловсруулж, хэрэгжүүлсэн.

Дээрх бүхэн нь Zenka Finance-ийн динамик өсөлтөд нөлөөлсөн бөгөөд 7 сарын хугацаанд 700,000 гаруй үйлчлүүлэгчдийн баазыг бий болгосон юм.

Эх сурвалж: www.fintechfutures.com

РЕГТЕК: ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД ҮҮЛЭН СИСТЕМД СУУРИЛСАН ТЕХНОЛОГИЙН КОМПАНИУДЫГ ШАЛГАЖ БАЙНА

“Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (FSB) нь Майкрософт, Амазон, Google зэрэг технологийн компаниудын үзүүлж буй үүлэн системийн үйлчилгээг судалж байна” гэж АНУ-ын Холбооны нөөцийн газрын

(Fed) захирагч Лазл Брейнард мэдэгдлээ. Олон улсын стандартын байгууллага болох Санхүүгийн үйлчилгээний хороо үүлэн системийн орон зайд технологийн аварга компаниуд зах зээлд ноёрхож байгаад анхаарал хандуулж эхэлж байна.

Статистик мэдээллээс үзэхэд Amazon Web Services (AWS) нь үйлчилгээний салбарын (IaaS) 47,8%-ийг эзэлж, Microsoft Azure (15,5%), Alibaba Cloud (7,7%), Google (4%), IBM (1,8%)–ийг тус тус эзэлж байна. Дээрх шилдэг таван үйлчилгээ үзүүлэгчид үйлчилгээний зах зээлийн 77 орчим хувийг эзэлдэг бөгөөд 2018 онд нийт үнэлгээ нь 31,3 хувиар өсч 32.4 тэрбум долларт хүрсэн байна.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь санхүүгийн үйлчилгээ, технологийн салбарын тайланд санхүүгийн байгууллагуудыг үндсэн үйл ажиллагааны дата, мэдээллээр хангаж буй технологийн компаниудад зохицуулагч байгууллагын зүгээс тавих хяналт нь одоогийн байдлаар сул байна гэж мэдээлжээ.

“Санхүүгийн байгууллагууд ихэвчлэн бизнесийн хэрэгцээ, шаардлага, цар хүрээнээс хамааран асар хурдтай өсөн нэмэгдэж буй худалдаа эрхлэгчдийг үүлэн системд нэг дор нэгтгэдэг” гэж тус тайландаа тусгасан байна.

Хэрэв үүлэн системийн хэрэглээ маш ихээр нэмэгдэж үйлчилгээ үзүүлэгчдийн дунд хэт их төвлөрөл үүсвэл үйл ажиллагааны доголдол, цахим гэмт хэрэг, төлбөрийн чадваргүй байдал үүсч олон санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг тасалдуулж болзошгүй юм.

Иймд үүлэн системд суурилсан үйлчилгээний хэрэглээ нэмэгдсэнээр хувийн компаниудын эрсдэлийг бууруулах боломжтой, мөн энэ нь бүхэлдээ санхүүгийн системд шинэ эрсдэл, сорилтыг үүсгэж болзошгүй юм.

Эх сурвалж: www.fintechfutures.com



СУДЛААЧИЙН ИНДЭР

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН СУДАЛГАА: ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОО

/2019 оны 2 дугаар улирлын судалгааны үр дүн/

Санхүүгийн зохицуулах хороо нь Үндэсний судалгаа, зөвлөгөөний төвөөр “Санхүүгийн зах зээлийн хэрэглэгчийн итгэлийг тандах судалгаа”-г улирал тутам гүйцэтгүүлдэг билээ. Энэхүү судалгааны зорилго нь иргэдийн санхүүгийн зах зээлийн оролцоо болон санхүүгийн байгууллагуудад итгэх итгэлийг судлахад чиглэсэн бөгөөд судалгаанд санамсаргүй түүврийн аргаар сонгосон 1,000 орчим иргэдийг хамруулдаг.

Түүвэр судалгаанд иргэдийн санхүүгийн зах зээлийн оролцоог даатгал, зээл болон хөрөнгийн зах зээлийн хүрээнд авч үзэн, голчлон үйлчлүүлдэг санхүүгийн байгууллага, бүтээгдэхүүн болон иргэдийн санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд итгэх итгэлийг тандах асуулыг оруулдаг.

“Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн энэ удаагийн дугаарт 2019 оны 2 дугаар улирлын байдлаар иргэдийн санхүүгийн зах зээлийн оролцоо хэр түвшинд буйг товч танилцуулж байна.

Судалгааны аргачлал: Судалгаа нь Монгол Улсын хэмжээнд явагдаж, санамсаргүй түүврийн аргаар сонгосон иргэдээс асуулга авах замаар мэдээллийг цуглуулдаг бөгөөд судалгааны асуулга нийт 3 бүлэг асуултаас бүрддэг.


2019 оны 2 дугаар улирлын судалгаанд нийт 1,011 иргэн хамрагдсан бөгөөд нийт оролцогчдын 42.1 хувь нь эрэгтэй, 60.8 хувь нь 35–аас дээш насны иргэд, 58 хувь нь техник мэргэжлийн болон түүнээс дээш боловсролтой, 51 хувь нь Улаанбаатар хотод оршин суудаг иргэд байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн амжиргааны түвшинг амьдардаг сууцны төрөл болон өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого гэсэн хувьсагчаар тодорхойлсон ба оролцогчдын 54.1 хувь нь гэр болон хашаа байшинд амьдардаг ба 70 хувь нь өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого 200,000 төгрөгөөс дээш өрхүүд байна.

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОО


Зээлийн зах зээл: Иргэдээс өнгөрсөн 6 сарын хугацаанд санхүүгийн байгууллагуудаас зээл авсан эсэхийг асуусан. Өмнөх улирлын судалгаанд оролцсон иргэдийн 40.2 хувь нь зээл авч байсан бол 2019 оны 2 дугаар улирлын байдлаар, иргэдийн 45.9 хувь нь зээл авчээ. Судалгаанд хамрагдсан иргэдийн 28.3 хувь нь арилжааны банкнаас, 8.7 хувь нь ББСБ–аас, 8.7 хувь нь барьцаалан зээлдүүлэх газраас, 7.0 хувь нь хувь хүнээс зээл авчээ.

Зураг: Иргэдийн зээл авсан байдал




Зээл авсан иргэд нас, хүйс, сууцны төрөл, орлого, ам бүлийн байдал, байршил зэргээрээ харилцан адилгүй байна. Нийт иргэдийн 45.9 хувь нь зээл авсан ч энэ нь хот, хөдөөгөөр харилцан адилгүй байна. Тухайлбал, Улаанбаатарын иргэдийн 43.6 хувь нь зээл авсан байхад хөдөөгийн иргэдийн 48.6 хувь зээл авчээ.

Зураг: Зээл олгосон байгууллага хотод




Зураг: Зээл олгосон байгууллага хөдөө орон нутаг



Хотын иргэдийн 35.2 хувь нь албан бус эх үүсвэрээс зээл авч байхад хөдөөгийн иргэдийн 24.2 хувь нь албан бус эх үүсвэрээс зээл авч байна. Арилжааны банкнаас хөдөөгийн, гэрт амьдардаг болон 35–аас дээш насны хүмүүс илүү их зээл авдаг байна. Харин ББСБ–аас хотын, орон сууцанд амьдардаг, боловсрол өндөртэй хүмүүс илүү их зээлдэг байна.


Даатгалын зах зээл: 2019 оны 2 дугаар улирлын байдлаар нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 30.3 хувь нь сайн дурын ямар нэг даатгалтай байна. Энэ нь 2018 оны 2 дугаар улиралтай харьцуулахад 9.6 пунктээр өсчээ. Нийт иргэдийн 64.9 хувь нь даатгалгүй гэсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.1 пунктээр буурсан байна.

Зураг: Ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаг эсэх



Сайн дурын даатгалтай эсэхээ мэдэхгүй гэсэн хариулт 0.3 пунктээр буурсан бол даатгалын талаар мэдэхгүй гэсэн хариулт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 пунктээр өссөн.

Зураг: Ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаг эсэх, бүлгээр




Сайн дурын даатгалд хамрагдалт нь иргэдийн боловсрол, орлого, сууцны нөхцөл болон хүйс зэргээс хамааран ялгаатай байна. Өндөр орлоготой, дээгүүр боловсролтой, орон сууцанд амьдардаг, эрэгтэй хүмүүс илүүтэй даатгалд хамрагддаг байна. Мөн түүнчлэн, боловсролын түвшин доогуур иргэд даатгалын талаар мэдэхгүй гэж илүүтэй хариулжээ. Тухайлбал, дээгүүр боловсролтой иргэдийн 3.1 хувь нь даатгалын талаар мэдэхгүй гэж хариулсан бол доогуур боловсролтой иргэдийн 6.6 хувь нь ийм хариулт өгчээ.

Өндөр боловсролтой иргэдийн 34.9 хувь нь даатгалд хамрагдсан байхад бага боловсролтой иргэдийн 24 хувь нь даатгалд хамрагдсан байна. Харин орон сууцанд амьдардаг иргэдийн хувьд 35.9 хувь нь даатгалтай байгаа нь гэр хороололд амьдардаг иргэдтэй харьцуулахад 10.4 пунктээр өндөр байна.

Даатгалд хамрагдаагүй иргэдээс хамрагдаагүй шалтгааныг тодруулахад 47.3 хувь нь хэрэгцээ шаардлагагүй гэж хариулсан. Энэ нь 2018 оны 2 дугаар улиралтай харьцуулахад 14.2 пунктээр өссөн байна. Харин даатгалын хураамж өндөр учраас хамрагдаагүй гэж 11.7 хувь хариулсан нь өмнөх оны мөн үеэс 5.4 пунктээр буурчээ. Даатгалд итгэдэггүй гэсэн хариулт 11.9 хувь байгаа нь 2018 оны 2 дугаар улиралтай харьцуулахад хэвэндээ байна. Харин даатгалын талаар мэдэхгүй гэсэн хариулт өмнөх оны мөн үеэсээ (31.8%) нэлээд буурч 24.9% болжээ.

Зураг: Даатгалд хамрагддаггүй шалтгаан




Хөрөнгийн зах зээл: Хөрөнгийн зах зээл бол санхүүгийн зах зээлийн нэг чухал салбар юм. Иймд энэхүү судалгааны хүрээнд хөрөнгийн зах зээлийн оролцооны талаар иргэдээс хэд хэдэн асуултаар мэдээлэл авсан.

Иргэдийн 17.2% нь хөрөнгийн биржийн арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож байсан гэж хариулсан бол 82.6% нь үгүй, 0.2% нь мэдэхгүй гэж хариулсан. Мөн 2018 оны 3 дугаар улирлын судалгаагаар энэхүү асуултад 30.1 хувь нь мэдэхгүй гэж хариулж байсан бол 2019 оны 2 дугаар улиралд энэ хариулт 0.2 хувь болж огцом буурчээ.

Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн ердөө 5.7% нь үнэт цаасны арилжаанд оролцож байжээ. Сонирхож байсан иргэдийн 23.6% нь өмнө нь хөрөнгийн биржийн арилжаанд оролцож байсан бол 76.4% нь оролцож байгаагүй байна. Эндээс үзэхэд сонирхож байсан иргэд ч үнэт цаасны арилжаанд оролцох байдал доогуур байна.

Боловсрол өндөр, орон сууцанд амьдардаг, өндөр орлоготой, эрэгтэй, хотод амьдардаг иргэдийн 20 гаруй хувь нь хөрөнгийн биржийн арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож байсан бол боловсрол бага, гэрт амьдардаг, орлого багатай, эмэгтэй, хөдөө амьдардаг иргэдийн 10 гаруй хувь сонирхож байжээ.


Зураг: Хөрөнгийн биржийн арилжаанд оролцох сонирхол



Хөрөнгийн биржийн арилжааг сонирхохгүй байгаа шалтгааныг асуухад 29.6 хувь нь арилжаанд хэрхэн оролцохоо мэдэхгүй, 70.0 хувь нь мэдээлэл байхгүй гэж хариулсан. Түүнчлэн, 12.2 хувь нь арилжаанд оролцох хөрөнгө, мөнгө байхгүй шалтгаанаар сонирхдоггүй байна.

Санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл болон мэдлэг: Судалгаанд хамрагдсан иргэдээс санхүүгийн зохицуулагч байгууллагууд болон зуучлагч байгууллагуудад итгэх итгэлийг 2016 оны 3 дугаар улирлаас хойш харьцуулан харах боломжтой болоод байна. Мөн түүнчлэн СЗХ, хөрөнгийн бирж, даатгалын компаниуд, арилжааны банк болон ББСБ-д итгэх итгэлийг тандсан дүнг харууллаа. 2019 оны 2 дугаар улирлын байдлаар санхүүгийн итгэх итгэлийн ерөнхий индекс 2018 оны мөн үетэй харьцуулахад үл ялиг буурч 43.2 хувь болжээ. Ийнхүү буурахад даатгалын компаниуд болон арилжааны банканд итгэх итгэл буурсан нь нөлөөлсөн. Тухайлбал, 2019 оны 2 дугаар улиралд арилжааны банканд итгэх итгэл өмнөх оны мөн үеэсээ 7.6 пунктээр, 2017 оны мөн үеэсээ 17 пунктээр буураад байна. Харин СЗХ болон ББСБ-д итгэх итгэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад тогтвортой, хөрөнгийн биржэд итгэх итгэл 3 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг: Санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл, нийт дүн



ДҮГНЭЛТ

Санхүүгийн зах зээлийн оролцоог даатгал, зээл болон хөрөнгийн зах зээлийн хүрээнд авч үзэн, голчлон авдаг үйлчилгээ, санхүүгийн зах зээлийн оролцоо, оролцохгүй байгаа шалтгааныг тодорхойлсон.

Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 45.9 хувь нь зээл авсан бөгөөд талаас илүү нь арилжааны банкнаас зээл авчээ. Хотын иргэдийн 43 орчим хувь нь, хөдөөгийн иргэдийн 63 орчим хувь нь арилжааны банкнаас зээл авчээ.

Сайн дурын даатгалд хамрагдалт нь иргэдийн боловсрол, хүйс, орлого болон сууцны нөхцөл зэргээс хамааран ялгаатай байна. Өндөр орлоготой бөгөөд өндөр боловсролтой, орон сууцанд амьдардаг иргэд илүүтэй даатгалд хамрагддаг байна. Мөн түүнчлэн, боловсролын түвшин доогуур иргэд даатгалын талаар төдийлэн мэдэхгүй байна.

Иргэдийн 17.2 хувь нь хөрөнгийн зах зээлд оролцохыг сонирхож байсан ч ердөө 5.7 хувь нь арилжаанд оролцож байжээ. Хөрөнгийн зах зээлд оролцох сонирхол бүлгүүдээр харилцан адилгүй байна. Хөрөнгийн биржийн арилжаанд оролцохгүй байгаа гол шалтгаан нь мэдээлэл байхгүй, хэрхэн оролцохоо мэдэхгүй нь судалгаагаар харагдлаа.



Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны ерөнхийлөгч З.Алтанзултай хийсэн ярилцлага



МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

Сайн байна уу та, Танд юуны өмнө юуны энэ өдрийн мэндийг хүргэе.

Баярлалаа. Танд ч гэсэн энэ өдрийн мэндийг хүргэхийн хамт ББСБ-ын салбарын талаар болон Холбооны үйл ажиллагааны талаар ярилцах болсонд талархлаа илэрхийлье.

Холбооны талаар бидэнд товч мэдээлэл өгнө үү?

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо нийт 250 гишүүнтэйгээр тогтвортой засаглал, бүтэц зохион байгуулалт бүхий мэргэжлийн холбооны үйл ажиллагааг 2002 оноос хойш явуулж байна. Өнгөрсөн хугацаанд санхүүгийн зах зээлд ББСБ-уудын эзлэх байр суурийг улам бэхжүүлэх, олон улсын жишигт хүргэн хөгжүүлэх, бичил болон жижиг, дунд бизнесүүд, иргэдэд санхүүгийн тогтвортой шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхэд дэмжлэг болох замаар Монгол Улсын нийгэм эдийн засагт тоймтой хувь нэмрээ оруулах эрхэм зорилго тавин ажиллаж байна.

Манай Холбоо бүх гишүүдийн хурлаараа удирдах зөвлөлийн 13 гишүүд, хяналтын зөвлөлийн 3 гишүүдээ сонгож, Удирдах зөвлөлөөсөө ерөнхийлөгчөө сонгон ажилладаг ил тод засаглалтай байгууллага юм. Бид 2019 онд байнгын 5 хороотой ажиллаж байгаа бөгөөд, Стратеги бодлого, Маркетингийн хорооноос гадна шинээр Санхүүгийн технологи, Тэнцвэртэй төлөөлөл, Зээлээс бусад тусгай зөвшөөрөлтэй ББСБ-

ын хороодыг байгууллаа. Үүнээс гадна Ёс зүйн түр хороог шинээр байгуулж гишүүн байгууллагуудад салбарын комплаенс ба ёс зүйг дээдлэн үйл ажиллагаагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Бидний үйл ажиллагаа 17 жилийн турш өргөжин тэлж, өнөөдөр нэгэнтээ гишүүдийнхээ нийтлэг эрх ашгийг хамгаалж, төрийн эрх барих болон зохицуулагч байгууллага, дотоодын болон олон улсын байгууллагуудын өмнө төлөөлөх, гишүүддээ цаг үед нийцсэн зөвлөмж мэдээлэл, сургалтуудыг хүргэх, салбарын тогтвортой болон эрсдэлгүй үйл ажиллагаанд онцгой анхаарч ажилладаг төрийн бус байгууллага болон олонд танигдсан байна.

Сүүлийн жилүүдэд ББСБ-ын салбар эрчимтэйгээр өргөжин тэлж Монгол Улсын хэмжээнд 538 ББСБ, Санхүүгийн зохицуулах хорооны хяналт зохицуулалтан дор хуульд заасан 10 төрлийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. Мөн ББСБ-ын салбар нийтдээ 2.3 сая харилцагчтай, 360 мянган зээлдэгчтэй, 1.5 их наяд төгрөгийн хөрөнгөтэй, банкнаас бусад санхүүгийн салбарын томоохон төлөөлөл болон бүрэлдээд байна. ББСБ-ын салбарт нээлттэй хувьцаат компани, олон улсын хөрөнгө оруулалт татсан, санхүүгийн технологид суурилсан ББСБ-ууд хүч түрэн орж ирж, компаниудын хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдэхийн хэрээр тогтвортой хөгжлийн төлөө холбоо улам ихийг хийж бүтээх үүрэг хариуцлага нэмэгдэж байна.

2019 онд Холбооны зүгээс ББСБ-ын салбарт бодлогын ямар ажлууд хийсэн бэ? Цаашид юу хийхээр төлөвлөж байна?

Холбооны зүгээс ББСБ-уудаа чадавхжуулах, санхүүгийн зах зээлд эзлэх байр суурь, санхүүгийн үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлж, ББСБ-уудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйн хэм хэмжээг тогтоох болон комплаенстай, хамгийн гол нь тогтвортой эрх зүйн орчинтой хөгжлийн асуудлуудад голлон анхаарч байна.

Бид СЗХ-той хамтран 6 дугаар сараас комплаенс, мэргэжлийн ёс зүй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах агуулгын хүрээнд нийт ББСБ-ын холбогдох ажилтнуудад зориулсан сертификатжуулах онлайн сургалтыг амжилттай явуулж байна. Энэхүү сургалтыг цаашид өргөжүүлэн энэ салбарт ажиллаж буй 3,000 гаруй ажиллагсдыг хамруулах зорилго тавьж байгаа бөгөөд өнгөрсөн гурван сарын хугацаанд нийт 400 гаруй ББСБ-ыг, үүнээс гишүүн байгууллагуудаа 100 хувь сургалтанд амжилттай хамруулж чадлаа.

Мөн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт оролцон салбарын онцлог, ирээдүйн чиг хандлагатай уялдуулан саналаа хүргүүлж СЗХ, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банкны зөвлөхүүдтэй хамтран ажиллаж байна.

Холбоо 5 дугаар сард Олон улсын Бичил санхүүгийн төвийн ээлжит хуралд ББСБ-уудын хамгийн өргөн төлөөлөлтэй оролцож, бичил санхүү болон санхүүгийн технологийн өнөөгийн чиг хандлага, зохицуулалтын орчны талаар мэдлэг мэдээлэл хуваалцан оролцлоо. Үүний үр дүнд ББСБ-уудыг олон улсаас хөрөнгө татахад шаардлагатай уулзалтуудыг хийж, мэдээллээр ханган дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Дэлхий даяар санхүүгийн технологийн шинэ үе хөгжин тэлж, санхүүгийн үйлчилгээ илүү хурдтай, хүртээмжтэй өсөлтийн үедээ байна. Манай салбарт одоогоор 6 ББСБ гар утсанд суурилсан зээл, цахим хэтэвчийн үйлчилгээ үзүүлж байна, цаашид ч нэмэгдэх хандлагатай байна. Энэ чиглэлээр хууль эрх зүйн орчин, мэдээлэл технологийн компани болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллаж, ойлголцолд хүргэх ажлыг Холбоо идэвхитэй өрнүүлж байна. Цаашид бид тогтвортой, хүртээмжтэй хөгжлийн шийдлүүдийг бодлогын хүрээнд дэмжиж, эрх зүйн орчныг бий болгохын төлөө ажиллах ба үүнд Холбооны Санхүүгийн технологийн хороогоороо дамжуулан чухал үүрэгтэй оролцох ёстой.

Нөгөөтэйгүүр, Холбоо ББСБ-уудын ёс зүйтэй үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Холбооны гишүүн байгууллагуудын баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг шинэчлэн баталж, зохицуулалтыг бий болгож өгсөн байгаа. Тухайлбал, харилцагч болон зах зээл дээр гишүүний хүлээх үүрэг, шударга байдал, хуулиа сахиж дагаж мөрдөх, харилцагчийг хамгаалах ёс зүйн зарчмуудыг гишүүн байгууллагууд дагаж мөрдөхийг уриалж байгаа заалтууд орсон. Үүнийг бид бодитой үр дүнд хүргэхийн тулд цаашдын сургалт, зөвлөгөөн, үйл ажиллагаандаа хэвшүүлж ажиллах болно.

Дашрамд дурдахад, Холбоо нь олон улсын харилцагчийг хамгаалах Smartcampaign-д нэгдээд найман жил болсон ба гишүүн байгууллагууд харилцагчийг хамгаалах 7 зарчмыг хэрэгжүүлээд ажиллаж байгаа. Мөн ТоС хөтөлбөрийг дэмжин ажиллаж, байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг дэмжих, тогтвортой санхүүжилтээр эдийн засагт хувь нэмрээ оруулахыг ББСБ-ууддаа уриалан ажиллаж байгааг дурдах нь зүйтэй.

Та сая харилцагчийг хамгаалах зарчим ярьлаа. Гишүүн байгууллагууд үйлчлүүлэгч, хэрэглэгчийнхээ эрх ашгийг хамгаалах талаар хэрхэн нэгдэж ажилладаг вэ?

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудал нь манай Холбооны зайлшгүй анхаарах, чухалчлан хэрэгжүүлэх ёстой асуудлын нэг гэж үздэг. Өөрөөр хэлбэл, харилцагчийн эрх ашгийг хамгаална гэдэг энэ салбарын цаашдын тогтвортой хөгжилтэй шууд холбоотой.

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах олон улсын зарчмын талаар дэлгэрэнгүй ярьж өгнө үү?

ББСБ бичил санхүүг дэмжиж харьцангуй бага орлоготой, санхүүгийн мэдлэг дутмаг иргэдэд зээл өгч байгаа. Тиймээс дараах зарчмууд маш сайн биелэгдэж байх ёстой.

Хэрэглэгчийг хэт өрийн дарамтад оруулахгүй буюу харилцагчиддаа бодит хэрэгцээ, шаардлагад нь нийцсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлнэ. Нөгөө талаас бүтээгдэхүүн үйлчилгээ хүргэх дизайн, суваг нь харилцагч төвтэй байж харилцагчид чирэгдэл эрсдэл учруулахгүй байх ёстой. Харилцагчид хүргэж буй бүтээгдэхүүн үйлчилгээний өртөг зах зээлийн дундаж өртгөөс хэт өндөр байх, тухайн санхүүгийн компанийн үйл ажиллагаа тогтворгүй байх зэрэг анхаарвал зохих асуудлууд ч байна. Мөн харилцагчтай харилцахдаа нээлттэй шударга зарчим

баримтална. Харилцагчийн мэдээллийн нууцыг хуулийн дагуу хамгаалж, зөвхөн авч буй санхүүгийн үйлчилгээнийх нь тухайн үеийн зориулалтын хүрээнд ашиглахыг анхааруулсан байдаг. Харилцагчийн гомдол санал хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, процесс бүхий механизмтай байх зэрэг долоон зарчим байгаа.

Энэ зарчимд одоогоор 80 ББСБ нэгдэн ороод үзэл санааг нь дэмжээд хэрэгжүүлэн ажиллаж байна. Цаашид энэхүү уриалгаа магадгүй, заавал мөрдөх журам болгох, энэ чиглэлд СЗХ-оос баримтлах бодлого болон ТоС хөтөлбөртэй уялдуулан хамтарч ажиллах, хөгжүүлэх шаардлагатай болов уу.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Холбооны зүгээс хэрэгжүүлсэн бусад арга хэмжээний талаар та дурдахгүй юу?

Холбооны зүгээс ББСБ-уудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, хамтын ажиллагааг сайжруулах, ББСБ-уудын үйл ажиллагааг олон нийтэд эерэгээр таниулах, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын хэмжээнд “Оюунлаг залуус–Монголын ирээдүй” нэгдсэн хандивын аян, “Оюуны эрэлд” эрдэм шинжилгээний хурал, “Бяцхан санхүүч миний хуримтлал” бүтээлийн уралдаан, “1,000 цүнх” хандивын аян зэргийг уламжлал болгон зохион байгуулж байна. Эдгээрээс гадна дээр дурдсанчлан, гишүүдтэйгээ хамтран Олон улсын харилцагчдын эрх ашгийг хамгаалах хөдөлгөөн /Smartcampaign/-д нэгдэн, Тогтвортой санхүүжилт /ТоС/ зарчмууд болон ББСБ-уудын үйлчилгээний стандартыг сайжруулах, хэрэгжүүлэх чиглэлд хамтран ажиллаж, хариуцлагатай санхүүгийн үйлчилгээг хүргэх зорилгоор ажиллаж байна.

ББСБ-ын салбарын онцлог юу вэ, мөн та цаашдын хөгжлийг хэрхэн харж байна вэ?

ББСБ бол цомхон бүтэцтэй, хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд шуурхай нэвтрүүлэх боломжтой, харилцагчид хамгийн ойр үйлчилж байгаа институци төдийгүй өрхийн үйлдвэрлэл эрхлэгч, бизнесийн үйл ажиллагаагаа дөнгөж эхэлж буй, барьцаа хөрөнгийн дутагдалтай, зээлийн түүхгүй, үйл ажиллагаа нь харьцангуй тогворжиж эхлээгүй, эсхүл шуурхай хэрэгцээ гарсан бичил, жижиг бизнес эрхлэгчдэд хамгийн тохиромжтой санхүүгийн үйлчилгээг хүргэдгээрээ онцлогтой.

Иймээс энэхүү институцийг ашиглаад санхүүгийн шинэлэг бүтээгдэхүүн технологид суурилсан үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх

бүрэн боломжтой юм. Жишээлбэл, сүүлийн 3 жилийн хугацаанд харилцагчийн тоо 500 мянга байснаас 4–5 дахин нэмэгдсэн, зээлдэгчийн тоо 5–6 дахин нэмэгдсэн нь Технологид суурилсан үйлчилгээтэй шууд холбоотой. Ирээдүйг санхүүгийн технологийн шийдэлгүйгээр төсөөлөхийн аргагүй болж байна. Гол нь өсөлтийг дагаж тогтвортой хөгжил байх нь чухал.

Мөн ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн шаталсан өсөлт нь энэ салбарт мэргэжлийн чадварлаг боловсон хүчинтэй, өөр өөрийн төрөлжсөн үйл ажиллагаатай байгууллагуудыг бий болгож, ирээдүйд харилцагчийн хэрэгцээнд улам ойр бүтээгдэхүүнийг өртөг багатайгаар хүргэх боломжийг бүрдүүлсэн. Сүүлийн жилүүдэд тооноос чанарт шилжих ажлуудыг Холбоо дэмжин ажиллаж байна.

Зээл, валют арилжааны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээ ББСБ-ын зах зээлд төдийлөн ахицтай нэвтэрч чадахгүй байгаа. Салбарын дунд болон урт хугацааны стратегийн хүрээнд бусад санхүүгийн

үйлчилгээг хөгжүүлнэ гэдэгт итгэлтэй байна. Гэхдээ үүнд шинэ хууль эрх зүйн орчин, олон улсын жишигт нийцсэн зохицуулалтын бодлого журмууд маш том дэмжлэг болно.

Ирээдүйд ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх, бичил жижиг бизнесийг дэмжих бага хүүтэй, зорилтот төрийн төсөл хөтөлбөрүүдийг үр дүнтэй, хурдан шуурхай хүргэх зэрэгт ББСБ-ын нөөц боломжийг дайчлах тэр цаг үе тун удахгүй ирнэ. Учир нь 1.16 их наяд төгрөгийн эздийн өмчтэй, мөн бичил, жижиг дундын салбарт өнөөдрийг хүртэл хугацаанд тогтвортой ажилласаар ирсэн салбарынхаа мэргэжлийн боловсон хүчний нөөц бололцоог үр ашигтайгаар ашиглах ёстой. Мөн түүнчлэн, 1.5 их наяд төгрөгийн нийт хөрөнгөтэй, 2.3 сая харилцагчийн баазтай энэ салбарт асар их боломжууд байна, гагцхүү тогтвортой хөгжлийг дэмжсэн, боломжуудыг бий болгосон тогтвортой бодлого байхад л болно.

Бодлогын түвшинд ямар шинэчлэлтүүд хийгдэх шаардлагатай вэ?

Төрийн төсөл хөтөлбөрүүдэд хамруулах, бизнесийн орчныг сайжруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, шинэ техник технологийг нэвтрүүлэх зэрэгт хууль эрх зүйн орчны хүрээнд шинэчлэлт хийх зайлшгүй шаардлагатай байна. Тухайлбал, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль анх 2002 онд батлагдсан бөгөөд уг хуулийг шинэчлэх, эрх зүйн орчныг сайжруулах хэрэгтэй.

Хамгийн чухал бодлогын шинэчлэл нь салбарын хөгжилд чөдөр тушаа болохгүй, тогтвортой оновчтой, шуурхай хийгдэж байх нь чухал байдаг.

Ярилцлага маань өндөрлөж байна. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа болон Холбооны талаар илэн далангүй яриа өрнүүлсэн танд баярлалаа. Танд болон танай Холбооны цаашдын ажил үйлсэд өндөр амжилтыг хүсье.

Баярлалаа. Танд ч мөн ажлын амжилтыг хүсье.



ӨРГӨН ДУРАН



"Санхүүгийн салбар дахь ББСБ-ын оролцоо" голч сэдвийн хүрээнд: Эдийн засагч, судлаач Ж.Дэлгэрсайхан

МОНГОЛЫН БАНКНЫ БУС САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА, БОЛОМЖ ИХ

Тантай өнөөдөр ББСБ, түүний үйл ажиллагааны талаар ярилцах болсондоо таатай байна. Юуны өмнө бичил санхүү гэж юу болох, энэ нь эдийн засагт ямар үүрэг гүйцэтгэдэг болох талаар манай уншигчдад энгийн байдлаар тайлбарлахгүй юу?

Юуны өмнө ярилцлагад урьсан та бүхэнд баярлалаа. ББСБ-ын үйл ажиллагааны талаар өөрийн бодлыг хуваалцахдаа таатай байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэдэг нь дэлхийн жишгээр харвал банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагааг хамруулан ойлгодог. Энэ чиглэлд даатгал, хөрөнгийн зах зээлийн чиглэлийн болон бичил санхүүгийн үйл ажиллагаа хамаардаг. Энэ чиглэлийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь банк, санхүүгийн үйл ажиллагаа хүрдэггүй, хамрагдах боломж бага, бага орлоготой иргэд, жижиг бизнесийн хүрээнд санхүүгийн үйлчилгээг хүргэх үүрэгтэй. Үүнд дээр дурдсан даатгал, мөнгөн гуйвуулга, зээл зэрэг үйл ажиллагаа мөн хамаардаг. Эдгээр үйл ажиллагаа нь албан болон албан бус зах зээл дээр хэрэгждэг гэж үздэг хэдий ч албан ёсны байдалтай байх нь зохимжтой болох нь тодорхой.

ББСБ-ын үйл ажиллагааг дэлхийн жишгээр бичил санхүүгийн үйл ажиллагаатай адилтгах боломжтой юм. Монгол Улсын хувьд ББСБ гэдэг нь ерөнхийдөө бичил санхүүгийн үйл

ажиллагаа, зээлийн чиглэлээр 1990 оны сүүлчээр анх бий болсон. Харин хөгжлийн явцад 2002 онд батлагдсан хуулийн хүрээнд ББСБ нэрийн доор бичил санхүүгийн үйл ажиллагаа буюу 10 орчим төрлийн үйл ажиллагааг хамруулсан. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд үүнийг зааж өгсөн бөгөөд үүн дотор үл хөдлөх хөрөнгийн барьцааны зуучлал, санхүүгийн зөвлөгөө гэх мэт үйл ажиллагаа ч байдаг. Энэ агуулгаар харвал бидний хувьд энэ чиглэлийн үйл ажиллагааг харьцангуй өргөн агуулгаар харж, хөгжүүлэхийг зорьж байна гэж ойлгож болох юм.

Ерөнхийдөө аль ч утгаараа энэ чиглэлийн үйл ажиллагаа нь банкны үйл ажиллагаанд хамрах боломж багатай бизнес, иргэдийг санхүүгийн үйлчилгээгээр хангах, түүгээрээ дамжуулан эдийн засагт ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулах чиглэлд тодорхой хувь нэмэр оруулж байх явдал гэж ойлгож болно гэж би хувьдаа үздэг. Дэлхийн банк зэрэг томоохон байгууллагуудын хувьд ч ингэж үздэг бөгөөд олон зуун сая хүн бичил санхүүгийн үйл ажиллагааны үр шимийг шууд болон шууд бус байдлаар хүртэж байдаг гэсэн судалгаа бий.

Та санхүүгийн салбар дахь ББСБ-ын оролцооны талаар судлаачийн хувьд санал бодлоо илэрхийлэхгүй юу? Ер нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн үйл ажиллагаа

нь юу болох, манай улс дахь ББСБ-уудын онцлогийг юу гэж харж байна вэ?

Монгол Улсад ББСБ-ын үйл ажиллагаа үүсэж хөгжсөн 20 гаруй жилийн хувьд эдийн засагт зохих хэмжээний үүргээ гүйцэтгэж ирсэн нь тодорхой. Энэ нь тухайн чиглэлийн байгууллагын талаарх хэдэн тоо баримтаас харагдана. Өнөөдөр Монгол Улсад 540 орчим ББСБ үйл ажиллагаа явуулж, түүнд 3,000 орчим хүн ажиллаж байна. Нөгөө талаас, тухайн салбарын үйл ажиллагаа 21 аймагт 2 сая гаруй хүнд хүрч үйлчилж байгаа нь салбарын үйл ажиллагааны хэрэгжилтийг харуулах томоохон үзүүлэлт юм. Салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2018 оноос их наяд төгрөгийг давсан, зээлийн хэмжээ 2019 онд мөн их наяд төгрөгийг давж банк, санхүүгийн салбарт эзлэх хувь өсч байгаа зэрэг нь салбарын үйл ажиллагаа ихээхэн амжилттай явж байгааг илэрхийлэх үзүүлэлт юм. Энэ хэрээр тухайн салбарын эдийн засагт гүйцэтгэх үүрэг нэмэгдэж байгаа нь сайшаалтай.

Олон улсын жишгээс харахад бичил санхүүгийн үйл ажиллагаа гэдгийг дээр дурдсанчлан банк, санхүүгийн үйлчилгээг тодорхой зорилтот бүлэгт хүргэх үндсэн зорилго бүхий хадгаламж, зээл, бусад санхүүжилт, даатгал болон бусад санхүүгийн үйлчилгээг хамруулан ойлгодог. Ингэхдээ зорилтот бүлэг гэдэгт бага орлоготой өрхүүд, бичил бизнес эрхлэгчдийг хамруулан ойлгодог бөгөөд энэхүү үйл ажиллагаанд донор байгууллагуудын оролцоо болон Засгийн газрын зүгээс хэрэгжүүлэх бодлогын дэмжлэг, дэд бүтэц, урамшуулал, харилцагч хэрэглэгчдийг хамгаалах асуудлыг чухалчилдаг. Чухамдаа энэ нь томоохон цогц бодлого, механизмын хүрээнд хэрэгждэг нийгэм, эдийн засгийн тодорхой зорилго бүхий үйл ажиллагаа юм.

Манай улсын хувьд энэ салбарын үйл ажиллагаа нь зээл, валютын арилжааны чиглэлд илүү их төвлөрсөн байдалтай хөгжиж байна. Ерөнхийдөө зээлийн чиглэлээр голчлон хөгжиж ирсэн бөгөөд 2007 оноос валют солих цэгийг СЗХ-ны хяналтад оруулж улмаар ББСБ-ын үйл ажиллагааны хүрээнд үйл ажиллагаа явуулах болсноор энэ төрлийн үйл ажиллагаа нь ББСБ-ын нэг голлох үйл ажиллагаа болсон харагддаг. Нийт ББСБ-ын 76 хувь нь зээл, валютын үйл ажиллагааг үндсэн үйл ажиллагааны хүрээнд дагнан

эрхэлж байна. Харин санхүүгийн зөвлөгөө өгөх, богино хугацааны санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, төлбөрийн баталгаа гаргах чиглэлд үйл ажиллагаа харьцангуй хязгаарлагдмал харагддаг.

Үүнээс гадна, олон улсын түвшинд бичил санхүүгийн үйл ажиллагаа нь дээр дурдсан зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа явуулж, тэрхүү үйл ажиллагаа нь ямар үр дүнд хүрсэн байдлаар салбарын үйл ажиллагааг дүгнэх хандлага байдаг. Жишээ нь: Бангладеш улсын Грэмин банк нь бичил санхүүгийн үйл ажиллагаагаар 7 сая орлого багатай буюу ядуу эмэгтэйчүүдэд үйлчилсэн нь ихээхэн амжилттай үйл ажиллагаа болсон гэж үздэг. Манай улсын хувьд бичил санхүүгийн үйл ажиллагаа нь банкны үйлчилгээнд хүрэх боломжгүй иргэдэд тодорхой хэмжээгээр хүрч байгаа нь илэрхий боловч тоо, чанар, үр дүнд болон хүртээмжийн хувьд яг ямар түвшинд байгаа талаар илүү тодорхой болгох чиглэлд анхаарал хандуулах цаг болсон мэт санагддаг. Иймээс бид бичил санхүүгийн үйл ажиллагааны төрөлжилт, хамрах хүрээ, зорилтот бүлэгт чиглэсэн байдалд анхаарах нь чухал. Үүн дээр төрийн бодлогын оролцоо ихээхэн чухал гэдэг нь ойлгомжтой. Энэ тухайд одоо үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг буруутгах боломжгүй юм.

Тэгвэл бид бичил санхүүгийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд цаашид ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай талаар таны байр суурь ямар байна. Та төрийн оролцоо чухал гэдгийг дурдлаа. Төр хэрхэн оролцох нь зохистой вэ?

Нэгдүгээрт: Одоо үйл ажиллагаа явуулж байгаа байдал нь өнөөгийн эдийн засгийн болон эрх зүйн орчноос шалтгаалж байна гэж харж байна. Тиймээс энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудыг тэгэх ёстой, тийм юм хийх нь хэрэгтэй гэх байдлаар хүчээр асуудалд хандах нь утгагүй юм. Харин хуульд заасан үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчныг хангалттай бүрдүүлэх шаардлагатай. Энэ хүрээнд миний ойлгож байгаагаар эрхлэх боломжтой үйл ажиллагаануудын хүрээнд тусгайлсан нарийн зохицуулалт төдийлөн байхгүй, дийлэнх нь Иргэний хууль гэх мэт хуулийн зүйл заалтын хүрээнд зохицуулагдаж байна. Гэтэл энэ нь өнөөгийн зах зээлийн хэрэгцээ шаардлага, санхүүгийн харилцааны онцлогт бүрэн нийцсэн эсэх нь эргэлзээтэй. Банк, санхүүгийн зах зээл дэх өнөөг хүртэл томоохон саад болж байгаа нэг асуудал нь барьцааны эрх зүйн асуудал байх жишээтэй.

Бичил санхүүгийн хүрээнд итгэлцлийн гэх мэт үйл ажиллагааны хувьд эрх зүйн бүрэн зохицуулалт байхгүй байна. Мөн зарим үйл ажиллагааны хувьд хязгаарлах зохицуулалт их байгаа нь тухайн төрлийн үйл ажиллагаа хөгжих боломжийг хязгаарлаж байх талтай. Үүнийг цэгцлэх нь эхний асуудал. Хоёрдугаарт: Бичил санхүүгийн үйл ажиллагаа нь тодорхой зорилтот бүлэгт чиглэсэн байх асуудлын хувьд төрийн зүгээс бодлогоор дэмжих хүрээнд олон улсын санхүүгийн байгууллагуудыг энэ чиглэлд татан оролцуулах, гадны төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг үр ашигтайгаар татах зэрэг асуудлуудад анхаарлаа хандуулах нь чухал юм.

Зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоох тухай асуудал хөндөгдөөд багагүй хугацаа өнгөрлөө. Энэ хугацаанд хүүгийн хязгаар тогтоох нь зөв, буруу гэсэн эсрэг байр суурийг, ялангуяа улс төрчид, төрийн эрх бүхий байгууллагууд болон банк, санхүүгийн байгууллагуудын зүгээс санал бодлоо илэрхийлсээр байна. Таны зүгээс ч судлаачийн хувьд байр сууриа илэрхийлсээр ирсэн. Энэ талаарх байр суурь болон ер нь манай улсын нөхцөлд зээлийн хүүг бууруулах чиглэлээр ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж та үздэг вэ?

Зээлийн хүүгийн асуудлыг тодорхой талуудын зүгээс ямар шалтгаантай нь тодорхойгүй хөндсөөр энэ асуудал нь банк санхүүгийн салбарын үйл ажиллагааны буруугаас бүхэлдээ хамааралтай мэт ойлголтыг нийтэд төрүүлж байгаа нь харамсалтай. Миний хувьд зээлийн хүү өндөр байгаа, түүнийг бууруулах шаардлагатай гэдэгтэй бүрэн санал нэг байгаа нь ойлгомжтой. Харин тухайн асуудлыг үндэслэлгүй дэврээх, улс төр хийх, иргэдийн санаа бодлыг сөрөг байдлаар хандуулах нь зохисгүй юм. Сүүлийн үед улс орны эдийн засаг бүрэн сайжраагүй, иргэдийн өрийн дарамт их байгааг далимдуулж улс төрийн хүрээнийхэн энэ асуудлыг өөрсдийн зорилгод ашиглах нь хэрээс хэтэрч байх шиг байна.

Шулуухан хэлэхэд, зээлийн хүүг хууль тогтоох замаар захиргааны аргаар хязгаарлах нь буруу. Энэ асуудлыг санал болгож байгаа талуудын хувьд тухайн эдийн засгийн орчны хүүний дээд хязгаар, зээлийн хүү гэдэг нь өөр ойлголт гэдгийг анхаарах нь чухал.

Зээлийн хүү гэдэг нь зээлийн бүтээгдэхүүний үнэ бөгөөд энэ нь эдийн засаг, нийгмийн, банк санхүүгийн салбарын, зээлдэгчийн гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалдаг учир шалтгаантай эдийн засгийн үзэгдэл гэдгийг

хаа хаанаа ойлгох нь чухал. Өнөөдөр Монгол Улсын зээлийн хүү өндөр байгаа нь улс орныг тогтвортой зөв бодлоготойгоор удирдаж чадаагүйгээс хамгийн их шалтгаалж байгаа гэж би хувьдаа үздэг.

Энэ тал дээр бид “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг тодорхойлж, хэрэгжүүлж байгаа нь зөв алхам юм. Ер нь зээлийн хүү бууруулахын тулд улс орныг удирдах бодлого тодорхой, тогтвортой байх түүнд үндэслэн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн хөгжил, бүтцийн асуудлыг зөв шийдэх нь суурь нөхцөлийг засах үндсэн арга юм. Үүний дараа микро орчны асуудлыг шийдвэрлэх боломжтой.

ББСБ-ын зээлийн хүү, зээлийн хэмжээний хувьд таны байр суурь ямар байдаг вэ? Мөн сүүлийн үед Монголбанкны зүгээс хэрэгжүүлж байгаа макро зохистой бодлогын хүрээнд өрхийн өр, орлогын харьцааг тогтоох замаар хэрэглээний зээлийг хязгаарлаж байгаа, энэ нь бичил санхүүгийн үйл ажиллагааны хувьд хамаарах ёстой юу?

Өмнөх асуултын хүрээнд зээлийн хүү нь олон хүчин зүйлээс буюу тухайн түвшний эрсдэлээс ихээхэн хамааралтай тухай дурдсан. Энэ агуулгаар бичил зээлийн хүү нь арилжааны банкны зээлийн хүүгээс өндөр байдаг. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй сайжирснаар банкны, бичил санхүүгийн салбарт хүүгийн түвшин харьцангуй буурч байгааг анзаарч байгаа байх. Энэ нь хүүний түвшний талаарх бидний маргааны хариулт болох учиртай. Бодлого тогтвортой, эдийн засгийн өсөлтийг удаан хугацаанд өндөр байлгаж чадвал хүү буурна. Энэ хүрээнд СЗХ-ны зүгээс бичил санхүүгийн зээлийн хүүг бууруулах асуудлыг бодлого, хөтөлбөрийн түвшинд үзэж тодорхой зорилго тавин ажиллаж байгаа нь зээлийн хүү бууруулахад эерэг нөлөө үзүүлэх боломжтой юм.

Өрхийн өр, орлогын харьцааны хувьд энэ нь өрхийг өрийн дарамтаас сэргийлэх үүнээс шалтгаалж өрх болон эдийн засагт эрсдэлийг бууруулах зорилготой гэж үзэж байгаа. Энэ агуулгаар харвал энэ нь бүх төрлийн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагад хамааралтай байх нь зүйтэй. Харин өөр нэг өнцөг нь энэ нь зөвхөн банкны салбарын эрсдэлийг бууруулах зорилготой, тухайн салбар нь олон харилцагч, хадгаламж эзэмшигчийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлдэг гэж үзвэл бичил санхүүгийн байгууллагад хамааралгүй байх боломжтой юм.

Гэхдээ өнөөдөр өрхийн өрийн дарамт өндөр болж энэ нь эргээд эдийн засаг, өрхүүдэд эрсдэл үүсгэх магадлалтай байна гэж би хувьдаа үзэж байгаа.

Та бидний ярилцлага өндөрлөж байна. Та ББСБ-ын салбарын цаашдын хөгжлийг хэрхэн харж байна гэсэн асуултаар ярилцлагаа өндөрлөө гэж бодож байна.

ББСБ нь өнгөрсөн 20 гаруй жилийн туршид санхүүгийн салбарын томоохон бүрэлдэхүүн болж хөгжсөн нь өнөөгийн тоо баримтаас тодорхой харагдаж байна. Энэ салбар нь хүний нөөц, хөрөнгө, санхүүгийн чадварын

хувьд бэхжэсээр байгаа нь харагдаж байна. Мөн энэ салбарт гадаадын хөрөнгө оруулалттай цөөнгүй байгууллага байгаа нь салбарын хөгжлийн нэг үзүүлэлт юм. Түүнээс гадна технологийн хөгжил өндөр хурдтай байгаа нь энэ зах зээлийн хөгжилд томоохон дэмжлэг болж байна. Мэдээллийн технологид суурилсан, төлбөр тооцоо, зээлийн үйлчилгээ дэлхийн хэмжээнд ихээхэн тэлж байна. Энэ бүгд нь тухайн салбарын үйл ажиллагааны цаашдын хандлагыг эерэгээр харахад хүргэж байна гэж хувьдаа бодож байна. Харин бодлого,

эрх зүйн орчин болон тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын хувьд энэ хөгжилд бэлэн байх нь чухал. Товчхондоо бүх чиглэлд тооцоо, судалгаатай, цаг үеэсээ хоцролгүй хурдтай ажиллахыг нөхцөл байдал биднээс шаардаж байна гэсэн үг юм.

Урилгыг маань хүлээж авч дэлгэрэнгүй ярилцлага өгсөн танд баярлалаа. Таны цаашдын ажил үйлсэд өндөр амжилтыг хүсье.

Баярлалаа. Танд ч мөн ажлын амжилтыг хүсье.


ХЭРЭГЛЭГЧ

2019 оны эхний хагас жилийн байдлаар ББСБ-уудын харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 1.6 дахин өсөж давхардсан тоогоор 2,348,014 хүрсэн бөгөөд харилцагчдын 91.5 хувийг финтек ашиглан үйлчилгээ үзүүлж буй 6 ББСБ-ын харилцагчид бүрдүүлж байна. Нийт харилцагчдын 49.8% нь эмэгтэй, 50.1% нь эрэгтэй, 0.1% нь хуулийн этгээд байна.


Зураг: ББСБ-уудын хүртээмж, дүүргээр



ББСБ-УУДЫН ХАРИЛЦАГЧИД



ББСБ-уудын хүртээмж, бүсээр: Монгол Улсын хэмжээнд 18-64 насны 100,000 иргэнд 37 ББСБ, 1,000 аж ахуйн нэгжид 18 ББСБ ногдож байна. Харин орон нутгийн хэмжээнд уг харьцаанууд нь 13:3 байгаа бөгөөд бүс нутгийн хувьд Төвийн бүсийн 100,000 иргэнд 18 ББСБ, Зүүн бүсийн 1,000 аж ахуй нэгжид 4 ББСБ ногдож байгаагаар хүртээмжийн үзүүлэлтээр тус тус тэргүүлж байна.




Улаанбаатар хотын хэмжээнд 18-64 насны 100,000 хүн ногдох ББСБ-ын тоо 67, 1,000 аж ахуйн нэгжид ногдох ББСБ-ын тоо 5 байна. Дүүргээр нь авч үзвэл энэхүү үзүүлэлтүүдээр Чингэлтэй болон Сүхбаатар дүүргүүд тэргүүлж байна.

Зээлийн үйлчилгээний тархалт: ББСБ-уудын зээлийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.4 дахин нэмэгдэж 360,345-д хүрлээ. Эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу 18-64 насны хүн амын тоог зээлдэгчдийн тоонд харьцуулсан дүн 6 байна. Өөрөөр хэлбэл, улсын хэмжээнд 18-64 насны 6 хүн тутмын нэг нь ББСБ-ын зээлийн үйлчилгээг хүртэж байна. Харин орон нутагт уг харьцаа 99, Улаанбаатар хотын хэмжээнд 3 байна.

ББСБ-аас зээл авсан иргэдийн тоо нэмэгдсэн нь санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж буйг илэрхийлж байгаа хэдий ч энэ нь нөгөө талаасаа иргэдийн өрийн дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэйг харуулдаг. Тийм учраас бид нэг зээлдэгчид ногдох зээлийн хэмжээг зайлшгүй харах шаардлагатай. 2019 оны 2 дугаар улирлын байдлаар ББСБ-аас нэг зээлдэгч дунджаар 3.0 сая төгрөгийн зээл авсан бол орон нутагт энэхүү үзүүлэлт 2.6 сая төгрөг, Улаанбаатар хотын хувьд 3.1 сая төгрөгийн зээлтэй байна. Харин уг үзүүлэлт өмнөх оны мөн үед 5.2 сая төгрөг байсан ба 2019 оны 2 дугаар улиралд ББСБ-аас зээл авсан нэг зээлдэгчид ногдох зээлийн дундаж хэмжээ 1.9 дахин буурсан байна.


Зураг: Зээлийн үйлчилгээний хүртээмж, байршлаар /сая төгрөгөөр/



ББСБ-уудын хүртээмж хүн амын үзүүлэлтээр:


ББСБ-уудын нийт харилцагчдын 49.8 хувь нь эмэгтэй, 50.1 хувь нь эрэгтэй байна. Нийт зээлдэгчдийн 57.9 хувь нь 18–35 насны, 25.9 хувь нь 36–45 насны, 11.9 хувь нь 46–55 насны, үлдсэн буюу 4.3 хувь нь 55-аас дээш насны хүмүүс байна.

Зураг: ББСБ-уудын зээлдэгчид, насны бүлгээр



2019 оны 2 дугаар улирлын байдлаар ББСБ-аас зээл авсан иргэдийн 60.1 хувь нь дээд боловсролтой, 6.5 хувь нь тусгай дунд боловсролтой, 30.5 хувь нь бүрэн дунд боловсролтой, 2.6 хувь нь дунд түвшний боловсролтой, 0.3 хувь нь бага боловсролтой иргэд байна.

Зураг: ББСБ-уудын зээлдэгчид, боловсролын бүлгээр



Дижитал санхүүгийн үйлчилгээний хүртээмж: Технологид суурилсан дижитал санхүүгийн үйлчилгээ нь сүүлийн жилүүдэд дэлхийн санхүүгийн салбарыг хурдтайгаар өөрчилж байгаа бөгөөд энэхүү хөгжлийг даган ББСБ-ууд ч дижитал санхүүгийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж эхлээд байна.


2019 оны 2 дугаар улирлын байдлаар улсын хэмжээнд 6 ББСБ технологид буюу гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж байгаа ба нийт зээлдэгчдийн 63.2 хувь нь уг үйлчилгээг хүртэж байна.

Гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээ нь бага дүнтэй, богино хугацаатай зээлийг түргэн шуурхай шийдэж өгдөг онцлогтой ба эдгээр байгууллагын хэрэглэгчдийн авсан зээл салбарын зээлийн нийт үлдэгдлийн 7.2 хувьтай тэнцүү байна. Харин гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээг авсан нэг иргэнд ногдох зээлийн дүн


336.0 мянган төгрөг байна.

Дижитал санхүүгийн үйлчилгээг хэрэглэгчдийн 50.4 хувь нь эмэгтэй, 49.6 хувь нь эрэгтэй байна. Харин зээлийн чанараар нь ангилан харвал нийт зээлдэгчдийн 93.2 хувь нь хэвийн, 3.9 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.9 хувь нь чанаргүй зээлдэгчид байна.

Зураг: Дижитал санхүүгийн үйлчилгээ хэрэглэгчид /хүйсээр/




Зураг: Дижитал санхүүгийн үйлчилгээ хэрэглэгчид /зээлийн чанараар/




18–35 насны иргэд дижитал санхүүгийн үйлчилгээнд бусад бүлгээс илүү хамрагдаж байна. Тухайлбал, 2019 оны 2 дугаар улирлын байдлаар гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээг хэрэглэгчдийн 67.8 хувь нь 18–35 нас, 19.9 хувь нь 36–45 нас, 9.2 хувь нь 46–55 нас, харин үлдсэн 3.1 хувь нь 55-аас дээш насны иргэд байна. Харин нийт зээлдэгчдийн 68.6 хувь нь дээд боловсролтой, 2.0 хувь нь тусгай дунд, 25.8 хувь нь бүрэн дунд, 2.2 хувь нь дунд боловсролтой байна.

Зураг: Дижитал санхүүгийн үйлчилгээ хэрэглэгчид /насны ангиллаар/



Зураг: Дижитал санхүүгийн үйлчилгээ хэрэглэгчид /боловсролын түвшнээр/



ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

2019 оны 2 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор 7.6 мянган хувь нийлүүлэгчдийн 538 ББСБ, Монгол Улсын 21 аймгийн 75 сум, Улаанбаатар хотын 8 дүүрэгт 235 салбар нэгж, 7 төлөөлөгчийн газар, 3.0 мянга орчим ажилтантайгаар 2.3 сая харилцагчдад хүрч үйлчилж байна. ББСБ-уудыг төвлөрлөөр авч үзвэл 463 ББСБ, 164 салбар Улаанбаатар хотод, 75 ББСБ, 71 салбар хөдөө орон нутагт бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.



2019 оны 2 дугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 1.5 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.0 хувиар буюу 389.4 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 19.3 хувиар буюу 248.2 тэрбум төгрөгөөр өсөж банкны салбарын нийт активын 4.4 хувьтай тэнцэж байна.

Активын бүтцээс харвал салбарын хөрөнгийн өсөлтийн 84.3 хувийг зээлийн өсөлт, пассивын бүтцээс харвал 47.4 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт тус тус бүрдүүлж байна.




Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 5.0 тэрбумаас дээш хөрөнгөтэй 48 ББСБ нийт активын 50.1 хувийг, 1.0–4.9 тэрбум хүртэл хөрөнгөтэй 379 ББСБ нийт активын 47.9 хувийг, 1.0 тэрбумаас доош

хөрөнгөтэй 111 ББСБ нийт активын 2.0 хувийг эзэлж байна.


Салбарын нийт зээлийн үлдэгдэл 1.1 их наяд төгрөгт хүрсэн нь банкны салбарын зээлийн үлдэгдлийн 6.2 хувьтай тэнцэж байгаа бөгөөд үүний 956.5 тэрбум төгрөг буюу 87.2 хувийг хэвийн зээл, 42.9 тэрбум төгрөг буюу 3.9 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 97.4 тэрбум төгрөг буюу 8.9 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа ба хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 51.5 хувьд эрсдэлийн сан байгуулсан байна.

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ



ББСБ-уудын пассивын бүтцийг харвал 75.3% буюу 1.2 их наяд төгрөг нь өөрийн хөрөнгө, 10.9% буюу 167.3 тэрбум төгрөг нь дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг, 5.5% буюу 84.1 тэрбум төгрөг нь итгэлцлийн үйлчилгээний өглөг, 2.2% буюу 33.8 тэрбум төгрөг нь ББСБ-аас гаргасан өрийн бичиг, 1.2% буюу 17.8 тэрбум төгрөг нь төслийн зээлийн санхүүжилт, 4.8% буюу 74.9 тэрбум төгрөг нь бусад өр төлбөр бүрдүүлж байна.

2019 оны 2 дугаар улирлын байдлаар 2.5 тэрбум төгрөгөөс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 66 ББСБ байгаа ба энэ нь нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 38.6 хувийг эзэлж байна. 1.0–2.4 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 345 ББСБ 57.0 хувийг эзэлж байгаа бол 0.9 тэрбумаас доош хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 128 ББСБ 4.4 хувийг бүрдүүлж байна.



Мөн ББСБ-ууд нь 158.3 тэрбум төгрөгийн орлоготой, 94.0 тэрбум төгрөгийн зарлагатай, 64.3 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Үүнээс 438 нь буюу ББСБ-ын 81.4% нь 68.1 тэрбум төгрөгийн ашигтай, 89 нь буюу 16.5% нь 3.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зохицуулалттай этгээд: 2019 оны 2 дугаар улирлын байдлаар 54 компани Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт

цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн 20 компани үйл ажиллагаа явуулж байгаа бол хөдөө аж ахуйн биржийн арилжаа, зуучлалын чиглэлээр арилжаа эрхлэх 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх 13 этгээд байна.

Арилжааны гүйлгээ:


Монголын Хөрөнгийн Бирж (МХБ): 2019 оны 2 дугаар улиралд хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 376.9 сая ширхэг хувьцааг 82.3 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ–ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 79.8 мянган ширхэг үнэт цаасыг 7.9 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 90.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийсэн байна.

Монголын Үнэт Цаасны Бирж (МҮЦБ): Тайлант улиралд МҮЦБ–ийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 9,000 ширхэг компанийн өрийн хэрэгслийг 90.0 сая төгрөгөөр, 5.1 сая ширхэг хувьцааг 228.9 сая төгрөгөөр тус тус арилжаалав.

МХБ болон МҮЦБ–ээр өссөн дүнгээр нийтдээ 90.5 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 4.6 тэрбум төгрөгөөр өсчээ.


Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар: 2019 оны 2 дугаар улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2,604.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 119.9 тэрбум төгрөг буюу 4.8 хувиар өссөн үзүүлэлт юм. Тайлант үед нийт 82.5 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдэж хөрвөх чадвар 3.2 хувь болов. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Зураг: Зах зээлийн үнэлгээ ба хөрвөх чадвар



ЗЗҮ/ДНБ–ий харьцаа: Тайлант улиралд ЗЗҮ–г 2018 оны жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн ДНБ–ний хэмжээтэй харьцуулахад 8.1 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Зураг: Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх зах зээлийн үнэлгээний хувь



Хувьцааны индекс: Олон улсад хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлыг тайлбарладаг бас нэгэн үзүүлэлт нь хувьцааны индекс байдаг. Тухайлбал, Нью–Йоркийн хөрөнгийн бирж болон Насдакийн хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг томоохон 500 компанийн зах зээлийн үнэлгээнд суурилан тооцдог Стандарт энд Пүүрс 500

(Standard and Poor’s 500 буюу S&P 500) индекс нь Америкийн хөрөнгийн зах зээлийн голлох үзүүлэлтүүдийн нэг юм. Манай орны хувьд “Монголын хөрөнгийн бирж” ХК–аас хоёр төрлийн индекс тооцдог. Хамгийн өндөр үнэлгээтэй 20 компанийн зах зээлийн үнэлгээнд суурилан тооцдог ТОП–20 индекс, үнэт цаасны бүртгэлийн I ба II ангилалд багтах компанийн зах зээлийн үнэлгээнд суурилсан MSE A болон MSE B индексүүдийг тооцож байна.

ТОП–20: Тайлант үед ТОП–20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 823.8 нэгжээр буюу 4.1 хувиар өсч 20,785.21 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 21,888.16 нэгж, доод үзүүлэлт 19,566.58 нэгж, дундаж үзүүлэлт 20,655.13 нэгж байна.

MSE A болон MSE B: Тайлант хугацаанд MSE A индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 80.87 нэгжээр буюу 0.8 хувиар буурч 9,743.03 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт нь 10,268.72 нэгж, доод үзүүлэлт нь 8,711.07 нэгж, дундаж үзүүлэлт нь 9,509.62 нэгж байна.


MSE B индексийн хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,517.15 нэгжээр буюу 15.7 хувиар буурч 8,116.71 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт нь 8,860.92 нэгж, доод үзүүлэлт нь 7,702.09 нэгж, дундаж үзүүлэлт нь 8,234.16 нэгж байна.

ХАА–Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөдөө аж ахуйн бирж нь анх 2013 оны 4 дүгээр сарын 05–ны өдрөөс хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаалж эхэлсэн ба үүнээс хойш 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 3.1 их наяд төгрөгийн арилжаа явуулжээ.

ХАА–н биржийн арилжаа: ХАА–н биржээр дамжин 2019 оны 2 дугаар улирлын байдлаар өссөн дүнгээр нийт 523.0 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 79.6 тэрбум төгрөг буюу 17.9 хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг: Хөдөө аж ахуйн биржийн арилжаа /тэрбум төгрөгөөр/



ХАА–н биржийн индекс: Хөдөө аж ахуйн бирж 2015 оноос биржийн индекс тооцоолж олон нийтэд мэдээлж эхэлсэн. MAPIX нь бирж дээр арилжаалагдаж байгаа бараа түүхий эдийн үнийг тусгай загвараар жигнэж тооцоолсон үнэ юм. Биржийн индекс нь сонгосон бүлэг бараа эсвэл салбар дахь барааны үнийг ерөнхий багцаар харах боломж олгодог. Тайлант улиралд MAPIX индекс хамгийн ихдээ 1,085,809.5 нэгж хүрсэн.

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ


Даатгалын зах зээлийн бүтэц: Даатгалын зах зээлд өнөөгийн байдлаар ердийн даатгалын 15 компани, урт хугацааны даатгалын 1 компани, давхар даатгалын 2 компани үйл ажиллагаа явуулж байна. Харин мэргэжлийн оролцогчдын хувьд 52 даатгалын зуучлагч компани байгаагаас давхар даатгалын зуучлагч 7, мөн даатгалын зуучлалын үйлчилгээ үзүүлэгч 9 банк байна. Даатгалын хохирол үнэлэгч 26 компани, 2493 даатгалын төлөөлөгчид тус тус СЗХ–оос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Даатгалын гүнзгийрэлтийн түвшин: Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүр болох даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ-д эзлэх хураамжийн орлогын хувь хэмжээ олон улстай харьцуулахад доогуур байна. 2019 оны хоёрдугаар улирлын байдлаар даатгалын гүнзгийрэлт 0.64 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.08 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Олон улсын хандлагаас харахад урт хугацааны даатгалын гүнзгийрэлт ердийн даатгалаас илүү өндөр хувьтай байдаг бол манай орны хувьд нөхцөл байдал эсрэгээрээ байна. Европийн болон Азийн зарим орнуудад урт хугацааны даатгалын гүнзгийрэлт 5 хувиас дээш, Өмнөд Африк болон Хятадад 10 хувиас дээш байхад манай орны хувьд сүүлийн жилүүдэд дунджаар 0.01 хувьтай байгаа юм.

Голлох үзүүлэлтүүд: Даатгалын зах зээлийн хэмжээг илэрхийлэх гол үзүүлэлтүүдийн нэг болох нийт хөрөнгийн хэмжээ даатгалын салбарын хувьд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 25.7 хувиар өсөж 354.7 тэрбум төгрөгт хүрсэн. Даатгалын салбарт давхар даатгалын нэг компани нэмэгдсэнтэй холбоотойгоор даатгалын салбарын хөрөнгийн бүтцэд өөрчлөлт гарсан ба давхар даатгалын нийт хөрөнгийн салбарын үзүүлэлтэд эзлэх хувь хэмжээ өнгөрсөн оны мөн үед 16.6 хувь байсан бол тайлант улирлын байдлаар 20.7 хувь болж өслөө. Салбарын нийт хөрөнгийн 76.7 хувийг ердийн даатгалын компаниудын хөрөнгө, 2.6 хувийг урт хугацааны даатгалын компанийн хөрөнгө тус тус эзэлж байна.


Зураг: Даатгалын салбарын нийт хөрөнгө, нөөц сан /тэрбум төгрөгөөр/



Харин нийт хураамжийн орлого өмнөх оны 2 дугаар улирлаас 23.7 хувиар өсөж 104 тэрбум төгрөг болов. Энэхүү өсөлтийн 99 хувийг ердийн даатгалын компаниудын нийт хураамжийн орлогын өсөлт бүрдүүлэв. Хураамжийн орлогын төвлөрүүлэлтийг авч үзвэл даатгалын зуучлагчид 19.7 тэрбум төгрөг буюу 18.9 хувийг, даатгалын төлөөлөгчид 22.1 тэрбум төгрөг буюу 21.2 хувийг бүрдүүлсэн байна.

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал тайлант улиралд 25.7 тэрбум төгрөгт хүрч, нийт хураамжийн орлогын 24.8 хувийг эзлэв. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 11.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 99 хувийг бүрдүүлж байна.

Зураг: Даатгалын салбарын нийт хураамжийн орлого, нөхөн төлбөр /тэрбум төгрөгөөр/



Даатгалын компаниуд өөрийн хүлээж авсан эрсдэлээ шилжүүлэх зорилгоор давхар даатгалын компаниуд даатгуулдаг. Манай орны хувьд дийлэнх даатгалын компаниуд гадны давхар даатгалын компаниуд эрсдэлээ даатгадаг ба тайлант онд даатгалын компаниуд нийт 33.7 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийн зардалтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 42.2 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд нийт хураамжийн орлоготой харьцуулахад 32.4 хувь байна.


Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 7.3 хувь, нийт хөрөнгийн өгөөж 3.7 хувь байна.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-дын тоо болон гишүүд: 2019 оны 2 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй хадгаламж, зээлийн хоршоодын тоо 275-д хүрч өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар буурлаа. Хоршоодын ажиллагсдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 3.4 хувиар нэмэгдсэн ба нийт ажиллагсдын 73.4 хувийг эмэгтэй ажилчид эзэлж байна.


Хадгаламж, зээлийн хоршоодын нийт гишүүдийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 10.4 хувиар буюу 6,347-ээр өсөж тайлант улиралд 67,524-д хүрсэн байна.

Зураг: ХЗХ-дын тоо болон гишүүдийн тоо




ХЗХ-дын хөрөнгө: Тайлант улиралд хоршоод нийт 210.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй ажилласан бөгөөд өмнөх оны мөн үеэс 19.6 хувийн өсөлтийг үзүүлж өнгөрсөн оны өсөлтөөс 16.4 пунктээр буурав.

Зураг: Нийт хөрөнгө, түүний өсөлт



ХЗХ-дын хадгаламж: Тайлант улиралд нийт хадгаламж 148.4 тэрбум төгрөг буюу өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19.2 хувиар өссөн. Нийт ХЗХ-дын 90.5 хувь буюу 249 ХЗХ нь нийт 148.4 тэрбум төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн бол үлдсэн 9.5 хувь буюу 26 ХЗХ нь огт хадгаламж татаагүй байна. Нийт хадгаламжийн 97.6 хувь нь хугацаатай хадгаламж бусад 2.4 хувь нь хугацаагүй хадгаламж эзэлж байна.

Зураг: Нийт хадгаламж, түүний өсөлт



Мөн хадгаламж, зээлийн хоршоодын нэг гишүүнд ногдох хадгаламжийн хэмжээ нь хангайн бүсэд хамгийн ихдээ 2.6 сая төгрөг, дунджаар 0.7 сая төгрөг байгаа ба зүүн бүсэд нэг хүнд ногдох хамгийн их хадгаламжийн хэмжээ 1.7 сая төгрөг, бүсийн дунджаар 0.9 сая төгрөг байна. Баруун бүсэд нэг хүнд ногдох хамгийн их хадгаламжийн хэмжээ 2.2 сая төгрөг, бүсийн дунджаар 0.4 сая төгрөгийн бага дүнтэй байгаа нь зарим хоршоо огт хадгаламж татаагүй байгаатай холбож болно. Харин төвийн бүсийн хувьд нэг хүнд ногдох хамгийн их хадгаламжийн хэмжээ бусад бүстэй харьцуулахад бага буюу 0.9 сая төгрөг, бүсийн дунджаар 0.4 сая төгрөг байна.

Тайлант улирлын байдлаар, хадгаламж, зээлийн хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгө өнгөрсөн жилийн мөн үеэс 19.7 хувь буюу 2.9 тэрбум төгрөгөөр өсөж 17.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин хоршоологчдын өмч өнгөрсөн жилийн мөн үеэс 34 хувиар буюу 4.7 тэрбум төгрөгөөр өсөж 18.6 тэрбум төгрөгт хүрсэн ба түүний бүрдэл болох нөөцийн сан 21.8 хувь, хуримтлагдсан орлого 51.1 хувийг эзэлж байна. Хадгаламж, зээлийн хоршоодын нийт орлого, зарлага

мөн адил өндөр өсөлттэй байгаа бөгөөд илүү дэлгэрэнгүйг ашигт ажиллагаа бүлгээс харах боломжтой.

Хүснэгт: ХЗХ-дын актив ба пассивын ерөнхий үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2018.И	2019.И	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Нийт хөрөнгө	176.1	210.6	34.5	19.6%
Нийт зээл	134.1	156.5	22.4	16.7%
Хэвийн зээл	121.7	145.3	23.5	19.3%
Хугацаа хэтэрсэн зээл	4.1	4.9	0.8	18.5%
Чанаргүй зээл	8.3	6.4	(1.9)	-22.5%
Хэвийн бус зээл	3.7	1.8	(1.9)	-51.5%
Эргэлзээтэй зээл	3.2	1.2	(1.9)	-61.4%
Муу зээл	1.4	3.4	2.0	145.5%
Хадгаламж	124.5	148.4	23.9	19.2%
Хугацаагүй	3.7	3.6	(0.1)	-3.5%
Хугацаатай	120.7	144.7	24.0	19.9%
Хувь нийлүүлсэн хөрөнгө	14.6	17.5	2.9	19.7%
Хоршоологчдын өмч	13.9	18.6	4.7	34.0%
Нийт орлого	19.3	24.4	5.1	26.3%
Нийт зарлага	18.2	21.5	3.3	18.1%
Нийт ашиг	1.1	2.9	1.8	161.9%

2019 ОНД БОЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

10 ДУГААР САРЫН 31

Дэлхийн хуримтлалын өдөр

11 ДҮГЭЭР САР 02

“Хөгжлийн төлөө хамтдаа” чуулган

11 ДҮГЭЭР САР

17th annual conference of the International Association of Insurance Supervisors /IAIS/, Abu Dhabi 201

Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IV байр.

+976-51-264444

www.frc.mn

Санхүүгийн зохицуулах хороо

Санхүүгийн зохицуулах хороо